

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА
СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

**ТАХИЛГАТ БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ,
СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ**



Улаанбаатар
2019

ННА 63.4

ДАА 930.1

А - 121



Рашаан хадны бэлгэдэл

☪ энэ дүрс бол Рашаан хаданд тамганы чуулбар дотор болоод дан ганцаараа ханан хадны дээд өнцөг, эхэн хавьд олонтаа сийлэгдэн үлджээ. Чингис хааны Самаркандад дэлдэгдсэн зоосон дээр ☪ дүрс бий бөгөөд үүнийг судлаачид Чингис хааны овгийн тамга гэж үздэг.

☪ мөн монгол адууны тамганд сүүлтэй онги буюу наран тамга гэдэг билээ.

☪☪☪ ийм дүрс нь дангаар мөн Рашаан хаданд олон бий. Судлаачид баавгайн сарвууны мөр гэдэг. Овог аймгийн эв нэгдэлтэй байхын бэлгэдэл ч гэж үзэж болно. Энэ хоёр эрхэм дүрсэлгээг нийлүүлбэл Рашаан хадны соёлыг төлөөлөх бэлгэдэл байж болно.

ТАХИЛГАТ БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

Зохиогч: Б.Даваацэрэн
Б.Цогтбаатар, Г.Анхсанаа

Редактор: Г.Энхбат
Эх бэлтгэсэн: Т.Энхтунгалаг
Хавтасны дизайнер: Ч.Амарзаяа
Цаасны хэмжээ: 60x90/16
Хэвлэлийн хуудас: 6,25х.х
Хэвлэсэн тоо: 300ш



«Соёмбо принтинг»
ХХК-д хэвлэв.

ISBN 978-99978-941-7-5

ГАРЧИГ

Өмнөх үг

4

Нэгдүгээр бүлэг.

БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

1.1.	Биндэр уул орчмын чулуун зэвсгийн судалгааны тойм	5
1.2	Биндэр уул орчмын булш, хиргисүүр, тахилын байгууламж	12
1.3	Дөрвөлжин булшны хөшөө чулуу	22
1.4	Үзүүр цохионы хадны зураг	29
1.5	Хажуу нуурын буган чулуун хөшөө	31
1.6	Өглөгчийн хэрэм	33
1.7	Баянголын амны хүн чулуун хөшөө	35
1.8	Дуган хадны өврийн чулуун зам	37
1.9	Биндэрийн энгэрийн чулуун байгууламж	38

Хоёрдугаар бүлэг.

РАШААН ХАДНЫ ДУРСГАЛ

2.1	Рашаан хад, түүний орчмын дурсгалыг судалсан байдал	40
2.1.	Хирст хад	46
2.2.	Кидан бичигт хад	46
2.3.	Тамгат хавтан чулуу	47
2.4.	Гол бичигт хад	48
2.5.	Хөрөгт хад	75
2.6.	Монгол бичигт хад	77
2.7.	Тамгат хэвтээ хад	78
2.8.	Зураг, бичигт хад	79
2.9.	Хөмсөг хад	81
2.10.	Морьт хад	82
2.11.	Янгирт хад	83
2.12.	Баавгайн мөрт хад	84
2.13.	Тамгатай жижиг хавтан чулуу	85
2.14.	Зурагт хад	86

Гуравдугаар бүлэг

БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

3.1	Биндэр уул орчимд хамгаалалтын бүс тогтоосон тухай	87
3.2	Рашаан хаднаа хийсэн багажит дүн шинжилгээний судалгааны тойм	89
3.3	Рашаан хаданд хийсэн 3 хэмжээст баримтжуулалт	92

Ном зүй:

95

ӨМНӨХ ҮГ

2009-2011 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харъяа Соёлын өвийн төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Япон улсын Токиогийн хүрээлэн, Нарагийн судалгааны хүрээлэнтэй хамтран Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Биндэр уул түүний орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах, хадгалалтын орчин нөхцөл, чулуулгийн бүтэц, эвдрэл гэмтлийг судлахаар «Great Khentii» төслийг хэрэгжүүлсэн. Бид энэхүү төслийн багт оролцож, тухайн бүс нутагт 3 жилийн турш ажиллахдаа Биндэр уул орчмоор тархсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар багагүй мэдээлэл цуглуулсны зэрэгцээ, зарим дурсгалын хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын талаар лабораторийн түвшинд боловсруулсан зохих үр дүн бүхий мэдээлийн сантай болсон юм. Энэхүү төслийн хүрээнд гүйцэтгэсэн бүртгэлийн болон бусад судалгаа шинжилгээний ажил нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын асуудлыг иж бүрэн, цогц хэлбэрээр зохион байгуулах зорилготой байсан бөгөөд зорилгоо бүрэн хэрэгжүүлсэн юм.

Бид төслийн хүрээнд хуримтлагдсан мэдээллийг олон нийтэд түгээж, Биндэр уул түүний орчмын дурсгалыг сурталчлан таниулах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, сургалт танин мэдэхүйн гарын авлага болгох зорилгоор энэхүү бэсрэг номыг хэвлүүлээ. Номын агуулгад орсон ихэнх мэдээллийг төслийг хэрэгжүүлэх явцад бичигдсэн хэвээр нэмж засварлалгүй оруулсныг тэмдэглэе.

«Great Khentii» төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хамтран оролцсон профессор А.Очир, доктор Ж.Саруулбуян, Батширээт сумын ИТХ-ын дарга Д.Гансүрэн, Засаг дарга М.Болд нар болон Япон улсын судлаач Такаши Мацукова, Козума, Футагами, Тамура, мөн төслийн үр дүнг бэсрэг ном болгон хэвлүүлж, олон нийтэд хүргэх боломжийг олгосон Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нарт гүн талархал илэрхийлье.

Номын цагаан буян машид дэлгэрэх болтугай.

Зохиогчид

Нэгдүгээр бүлэг.

БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

1.1. Биндэр уул орчмын чулуун зэвсгийн судалгааны тойм

Хэнтий аймгийн Батширээт сумын Хурх багийн нутагт орших Биндэр уул нь Хан Хэнтийн нурууны зүүн өмнөд үзүүр хэсэгт хамаарах, байгалийн өвөрмөц экосистемийн бүрдэл төдийгүй түүх соёлын үнэт өв санг хадгалсан газар нутаг юм.

Биндэр уул нь хуучнаар Сэцэн хан аймгийн Хөвчийн Жонон вангийн хошууны гол тахилгат уулын нэг байсан бөгөөд өдгөө ч Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр сумд жил бүр ээлжлэн тахидаг байна. Халхын анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар Ононгийн халуун рашаанд бараалхаад буцах замдаа Биндэрийн овоонд саатан "Буян-Овоо" хэмээн нэрлэж тахисан тухай академич Х.Пэрлээ тэмдэглэжээ.

Биндэр уулын овооны ойр орчимд (1-10км) чулуун зэвсгийн суурин, олон үеийн булшнууд, хадны зураг, хэдэн зуун тамга тэмдгийн дурсгал, монгол, төвд, нанхиад, кидан, араб, түрэг зэрэг нийт 60 гаруй бичээстэй хад, буган хөшөө, хүн чулуун хөшөө, эртний бэхлэлт хэрэмний үлдэц зэрэг түүхийн урт удаан он цагт хамаарах олон төрлийн дурсгалууд нэгэн дор харьцангуй бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн байна. Цаашид судлах, хадгалж хамгаалах нэн шаардлагатай тул "хүн төрөлхтний түүх соёлын хосгүй үнэ цэнэтэй өв мөн" хэмээн үзэж Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад «Тахилгат Биндэр уул түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар» нэрээр 2014 онд бүртгүүлсэн билээ. «Монголын нууц товчоон»-д бичигдсэн Бидэр хошуу (Биндэр овоо, Рашаан хад), Хорчухуй болдог (Өглөгчийн хэрэм), Хулдгар хун (Биндэр уул), Хорхунаг жубурын хөндий (Хурхын хөндий), Химурга горхи (Жаргалант, Хурхын гол) зэргийг тойрон Монголын түүхийн олон чухал үйл явдал энэ бүс нутагт болж өнгөрчээ.



УИХ-ын 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Биндэрьяа хан уулыг "Байгалийн дурсгалт газар"-ын ангиллаар нийт 5736 га талбайг хамруулан улсын тусгай хамгаалалтад авсан байна.

Биндэр уулын эргэн тойрны ам, хөндийн гол, горхи, нуур цөөрмийн эрэг, салбар уулсын энгэр бэлээр эрт үеэс хүн суурьшин хөдөлмөрийн багаж зэвсгээ үйлдэн амьдарч байсны ул мөр олон бий.

Чулуун зэвсгийн үеийн дурсгалын гол төлөөлөл нь Рашаан хадны суурин бөгөөд уг дурсгалт газрын тухай 1920-иод онд нутгийн ард Цэдэнгийн Хайдавданзан Судар Бичгийн Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээнд анх мэдээлжээ [Пэрлээ, 1976]. Археологийн талаар судлах ажлыг Д.(Х).Пэрлээ 1943 оноос эхлүүлсэн бөгөөд 1960-1980 онд олон удаа судалгаа хийж олдвор хэрэглэгдэхүүндээ тулгуурлан эрдэм шинжилгээний ба сурталчилгааны өгүүлэл арав гаруйг бичиж нийтлүүлсний гадна, хаданд сийлсэн олон зуун тамгыг судалж нэгэн сэдэвт бүтээл тууриг [1976] билээ.

Түүнчлэн, 1949 онд К.В.Вяткинагийн удирдсан угсаатны зүйн шинжилгээний анги Биндэр уул орчмоос чулуун зэвсгийн олон тооны үлдэгдэл илрүүлэн товч нийтэлсэн [Вяткина, 1951] байна.

1953 онд Х.Пэрлээ Хэнтий аймгийн Батширээт сумын Өглөгчийн Хэрэмний орчмоос таргил үлдэц, үзүүр мэс, хянгар, хусуурууд, Рашаан хадны орчмоос цахиураар хийсэн үзүүр мэс, цүүц зэрэг дунд, дээд палеолитын үед холбогдох зэвсгийн зүйл олсон бөгөөд тэдгээрийн заримыг Ц.Доржсүрэн хэвлүүлжээ [1957].

1963 онд Л.Ийсл, Н.Сэр-Оджав нарын удирдсан Монгол-Чехословакийн хамтарсан шинжилгээний анги Хэнтий аймгийн умард хэсгийн нутгаар хайгуул судалгаа хийх явцдаа Биндэрийн Рашаан хадны хойд талд орших Үзүүр цохионы хадны зургийг баримтжуулж, 1965 онд эрдэм шинжилгээний тодорхойлолт, гэрэл зургийн хамт нийтлүүлсэн [Limur Jisl, 1995] ажээ.

Рашаан хадны чулуун зэвсгийн сууринг Х.Пэрлээгийн удирдсан Гурван голын шинжилгээний анги 1973, 1974 онуудад туршилтын журмаар малтсан [Цэвээндорж, 1988], бөгөөд 1980



онд А.П.Окладников, Д.Дорж, 1981 онд Р.С.Васильевский, Д.Цэвээндорж нарын удирдсан МЗТСХЭ-ийн Палеолитын дурсгал судлах анги үргэлжлүүлж малтан 2,5-3,5 м гүн, дөрвөн үе соёлт давхрагатай болохыг тогтоосон [Окладников, Васильевский 1982; Цэвээндорж, 1988] байна. 1981 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсэг судлалын анги Рашаан хадны баруун талд орших Ханангийн жалганаас үлдэц, хусуур зэрэг палеолитын үед холбогдох нэлээд тооны эдлэл олжээ [Цэвээндорж, 1981].

Рашаан хадны чулуун зэвсгийн судалгааг 1980-1981 онд МЗТСХЭ-ийн Чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн судлаачид үргэлжлүүлэн гүйцэтгэж шинэ олдвор хэрэглэгдэхүүн цуглуулсан байна. Тухайлбал, 1980 онд урт нь 10 м, өргөн нь 4 м буюу 40 м² талбайд малтлага хийж чулуун зэвсгийн дурсгалыг агуулсан 2.5 м зузаан (доод хэсгээр зарим буландаа 3 м), дөрвөн соёлт давхаргатай болохыг тогтоосон бол 1981 онд Рашаан хадны чанх урд хэсэгт 5x2 м хэмжээтэй талбайд малтлага хийж, шинэ соёлт давхарга илрүүлжээ. [Монголын чулуун зэвсгийн судалгаа, 2016: 50, 53].

Монгол-Японы хамтарсан «Гурван гол» төслийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдхүүнд оролцсон археологчид 1991 онд Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нутаг Онон, Хурхын голын сав газарт ажиллахдаа Биндэрийн Рашаан хад, Асгат уулын энгэр, Өглөгчийн үзүүр, Ганц модны жалга зэрэг газраас баргил хянгар, хусуур, залтсан хусуур, дугуй үлдэц зэрэг палеолит, неолитын үед холбогдох чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэн тайландаа дурьдсан [Гурван гол, 1991] байна.

1998 онд Монгол-Солонгосын хамтарсан «МонСол» төслийн хээрийн шинжилгээний анги Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн голын сав дагуу хайгуул судалгаа хийж, голын эрэгт чулуун зэвсгийн малтлага судалгаа гүйцэтгэн мянга гаруй олдвор илрүүлсэн [Мон-Сол» төслийн тайлан. 1999] байна.


Голын эрэг дагуу гүний чийг усанд ойрхон талбайд малтсан тул соёлт давхрагын зузаан харилцан адилгүй боловч анхдагч болон хоёрдогч боловсруулалт хийсэн арга, зэвсгийн цуглуулгын хувьд Рашаан хадны дурсгалтай ойролцоо бөгөөд дээд палеолитоос неолитын үед хамаарахыг тогтоожээ.



Археологич Б.Цогтбаатар ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологийн лабораторид хадгалагдаж буй Рашаан хадны чулуун зэвсгийн суурингийн 1980, 1981 оны малтлагаас илрүүлсэн нийт 8000 гаруй чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, нийтэлүүлсэн [Цогтбаатар, 1999] юм.

2006-2008 онд Монгол-Японы хамтарсан «Зүүн Монголын чулуун зэвсгийн судалгаа» төслийн хээрийн шинжилгээний анги Рашаан хад, Өглөгчийн голын эх орчимд хайгуул болон малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна.

Тухайлбал, 2006 онд Рашаан хадны чулуун зэвсгийн сууринд хорь гаруй жилийн өмнө МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн хийсэн малтлага судалгааны зарим дүгнэлтийг газар дээр нь нягтлан, хамгийн доод соёлт давхаргын зааг үеийн талаар мэдээлэл олж авах зорилгоор туршилтын малтлага хийсэн [Цогтбаатар нар..., 2010:32-33]. байна. Түүнчлэн дээрх экспедицийн хүрээнд 2007-2009 онд Онон, Хурх, Өглөгч, Эгийн голын сав нутгаар нарийвчилсан хайгуул, туршилтын малтлага судалгаа хийж олон шинэ дурсгалт газруудыг илрүүлсэн [Цогтбаатар нар..., 2010:] юм. Биндэр уулын Дулын гозгор хэмээх уулаас зүүн хойш Өглөгчийн голын гармын хойд талын модтой уулын энгэрт орших шовх байц хадтай цохиог Улаан хад гэх бөгөөд уулын энгэр бэл, хормойгоос чулуун зэвсэг олддог. Улаан хадны урд ёроолд баруун урд зүг хандсан үүдтэй байгалийн тогтоц бүхий хадан хонгилыг Монгол-Японы хамтарсан дээрх экспедицийн хүрээнд 2009 онд илрүүлэн, бага талбайд туршилтын малтлага хийхэд ногоон, шаргал, улаан, хүрэн өнгийн цахиур чулуугаар үйлдсэн сумны зэв, зэвний хугархай харьцангуй олон тоогоор илэрсэн нь маш сонирхолтой юм.



Улаан хадны чулуун зэв



Улаан хадны сурвалжтай зэв болон өргөн сурвалжтай зэв нь Байгал нуур орчмын дурсгалуудаас нэлээд түгээмэл олддог бөгөөд шинэ чулуун зэвсгийн үед холбогдоно. Тус дурсгалыг цаашид нарийвчлан судлах, хадгалж хамгаалах шаардлагатай.

2009 онд Биндэр уулын орчимд хайгуул судалгаа хийсэн «Great Khentii» төслийн бүртгэлийн багийн удирдамжид чулуун зэвсгийн судалгаа хийх төлөвлөгөө ороогүй боловч хайгуулын ажлын үеэр газрын хөрсөн дээр ил тааралдаж байсан хэдэн арван чулуун зэвсгийн үлдэгдлийг түүвэрлэн гэрэл зургаар баримтжуулсан байна.



Гилбэр хэлбэрийн иртэй хусуур-2.



Леваллуа үзүүр мэс-2.



Леваллуагийн үзүүр мэс.



Рашаан хад, Гилбэр хэлбэрийн иртэй хусуур.

2011-2014 онд Монгол-Солонгосын хамтарсан «IA-SNU» чулуун зэвсгийн судалгааны төслийн хүрээнд дөрвөн газар сонгон малтлага хийж, геологийн 5 давхарга байгаагаас 1, 2-р үе буюу өнгөн хөрс, хар шороон давхарга неолит, 3-р үе буюу давхаргын доод улаан шаргал, 4-р үеийн дээд хэсэг калци ихтэй давхарга дээд палеолит, 5-р үе буюу хүрэн давхарга дунд палеолитоос



дээд палеолитод холбогдохыг тогтоосон [Гүнчинсүрэн нар., 2015:16] байна. Дээрх гурван удаагийн малтлагаас илрүүлсэн олдвор, эд өлгийн зүйлс нь маш жижиг ялтас, үлдцээс эхлээд хэдэн төрлийн амьтны яс зэргийг багтаасан 8 мянга орчим ширхэг бөгөөд зөвхөн 2014 онд 4302 ширхэг олдвор илрүүлжээ. Эдгээрийн дотор амьтны ясны үзүүрийг шовхлон засаж хийсэн багаж болон хэрчээсний дөрвөн зураас ул мөр тод үлдсэн ясны үлдэгдэл зэрэг онцлог олдворууд байжээ.

Чулуун зэвсгүүдтэй холилдон олдсон ясны [зэрлэг адуу (Equus), үхэр (Bos)] дээжний шинжилгээгээр энэ давхарга нь 35630 ± 180 (IAAA-110745; 41340~40353 calBP at 95.4%), 35070 ± 180 (IAAA-110746; 40905~39436 calBP at 95.4%) жилийн өмнө холбогдох он цагийн хамаарал гарсан [Гүнчинсүрэн нар., 2015:16] байна. Чулуун зэвсгийн дийлэнх нь засаж янзлаагүй залтас болон хаягдал ялтаснууд байсан хэдий ч 2014 оны малтлагын явцад хөрсний доод давхрагаас мустьен үеийн үйлдвэрлэлийн аргаар үйлдсэн 3 ширхэг чулуун зэвсэг илрүүлжээ. Энэхүү баримт нь Рашаан хадны чулуун зэвсгийн суурин нь Евразийн бүс нутгийн хамгийн зүүн захын мустьен үйлдвэрлэлийн арга нэвтэрсэн дурсгалт газар болохыг харуулж байна хэмээн судлаачид онцолсон [И Сонбук, 2018:21] байна.

Чулуун зэвсгийн үеийн хадны зургийн тухай


Рашаан хаданд сийлсэн олон тооны тамга, тэмдэг хүн амьтны дүрс зураг, түүхийн өөр өөр үед хамаарах бөгөөд ялангуяа чулуун зэвсгийн үед холбогдох цөөн хэдэн зураг маш сонирхолтой, эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой юм.

Рашаан хадны баруун хэсгийн ханан хаданд хэсэг амьтан дүрсэлсэн ба хамгийн зүүн дээд талд дугуйдуу сэрвээтэй, богино бүдүүн хөлтэй урт хошуутай нэгэн амьтны ерөнхий тэгийг хөвөөлөн дүрсэлснийг Монгол болон Оросын Урал, Европ тивийн агуйнуудын дээд палеолитын зурагтай харьцуулан, «арслан зааны зураг» хэмээн үзсэн [Цэвээндорж, 1998] байдаг. Үүнийг өнөөг хүртэл төдий л олон судлаачид үзээгүй, нарийвчлан судлаагүй байна.

Мөн тамгат хавтангийн зүүн талд орших нэгэн том хавтгай хадны урагш харсан тэгш талбайд, зүүн тийш сүрэглэн явж буй



гурван амьтны дүрсийн ерөнхий тэгийг хөвөөлөн цохиж гаргасныг савагт хирс (Woolly rhinoceros)-ний дүрс зураг хэмээн судлаачид үздэг. Рашаан хадны чулуун зэвсгийн олон соёлт давхарга бүхий



Арслан зааны зураг

сууринг малтан шинжлэхэд 1.5 м гүнээс чулуун зэвсгийн хамт савагт хирсний шүд олдсон [Цэвээндорж, 1988] ба тэндээс хэдхэн алхмын зайтай нэгэн хавтгай хаднаа сүрэглэн явж буй гурван савагт хирсийг ихэд бодитой сийлж дүрсэлсэнтэй шууд нөхцөлддөг юм. Түүнчлэн, Рашаан хад, Үзүүр цохионы хэд хэдэн газарт байвгайн сарвууны дүрс нийт 20 шахам тоотой сийлж үлдээсэн нь неолитын үед хамаарах баавгай шүтлэгийн тодорхой баримт болно.

Ийнхүү Биндэр уул орчмын дурсгалт газрууд нь мустьен төгсгөл үеэс неолитын эцэс хүртэлх үеийн үйлдвэрлэлийн арга техник, хувьсал, хөгжлийн үе шатуудыг тодорхой харуулдаг, эртний хүний шүтлэг бишрэл, танин мэдэхүйн хөгжил, байгаль экологийн орчны төлөв байдлыг тодорхойлох чухал баримтуудыг хадгалсан Монголын төдийгүй Зүүн хойд Азийн чулуун зэвсгийн үеийн судалгаанд чухал ач холбогдолтой үнэт өв юм.



Чулуун зэвсгийн үеийн хадны зураг



1.2 Биндэр уул орчмын булш, хиргисүүр, тахилын байгууламж


Биндэр уулын эргэн тойронд түүхийн олон үед холбогдох янз бүрийн хэлбэр төрхтэй маш их булш, хиргисүүр, тахилын байгууламж бий. Эдгээрийн дийлэнх нь цагийн уртад байгалийн нөлөөнд автаж хэлбэрээ алдсан, хүний гарт өртөн эвдэрч сүйдсэн байв. Зарим нь уулын өврөөр явах машин замд ч дайрагдсан харагдана.

Биндэр уулын өврийн дөрвөлжин булшийг 1960-аад оны үеэс эхлэн Х.Пэрлээ малтан судалсан [Наваан 1975:26; Пэрлээ 2001:30] байна. Мөн Д.Наваан нарын археологчид Үзүүр цохионы өмнө орших 20-иод булшнаас 4-ийг нь малтан судалсан [Наваан 1975: 26] байдаг. Дурдсан судалгаанаас өөр Биндэр орчмын булш, хиргисүүр, тахилын байгууламжийг малтан судалсан судалгааны ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Энд зориуд нэг зүйлийг дурдахад Биндэрийн орчим манай ахмад археологчдын хийсэн малтлага судалгааны ажлын ул мөрийг гэрчлэн онгойж овоорсон, эвдэрч сүйтгэсэн булшны хэрэглэгдэхүүн олонтоо тааралдаж байна. Булш нь эртний судлалын шинжлэх ухааны судалгааны гол объект мөн ч гэсэн нэгэн цаг үед бидэнтэй адил амьдарч байсан хүний дурсгаланг хадгалж буй хүндтэй газар юм. Иймийн тул булш, оршуулгыг судлахдаа аль болох хүндэтгэлтэй хандаж, судалгааны ажлынхаа дараа эргэн булж нөхөн сэргээх нь судлаачийн ёс зүй, цаашлаад монгол хүний ихэс дээдсээ хүндэтгэн дээдлэх язгуур жудагт нийцсэн үйлдэл болох болов уу гэж санана.

Биндэр уулын эргэн тойронд буй булш, хиргисүүр, тахилын байгууламж нь хэлбэр, хэмжээний хувьд харилцан адилгүй байхын зэрэгцээ Монгол нутагт тэр бүр тохиолдоод байдаггүй хэд хэдэн шинж тэмдэгтэй байна. Тухайлбал, дөрвөлжин булшны зүүн талд хөшөө босгосон тохиолдол, дөрвөлжин булшны хашлага чулуун дээр эгнэн зогссон олон хүн дүрсэлсэн зэрэг нь эрдэм шинжилгээний хувьд онц сонирхолтой шинж тэмдгүүд юм.


Бид Биндэр уулын орчмын булш, хиргисүүр, тахилын байгууламжуудыг газрын гадарга дээрх хэлбэрээр нь бүлэглэн бүртгэсэн болно.




Дуган хадны дөрвөлжин булш, булшны хавтангийн зураг

1. Хиргисүүр


Д/А	Дурсгалын нэр	Тоо ширхэг	Байршил
1	Хиргисүүр тахилын байгууламжийн хамт	1	N 48° 22,66 E 110° 18,15
2	Хиргисүүр	1	N 48° 22,13 E 110° 17,95
3	Хүрээгүй том хиргисүүр	1	N 48° 25,00 E 110° 17,85
4	Дугуй хүрээтэй хиргисүүр	1	N 48° 22,17 E 110° 15,49
5	Тахилын байгууламж бүхий хүрээгүй хиргисүүр	1	N 48° 22,66 E 110° 18,15
6	Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр Хүрээгүй жижиг хиргисүүр	1 1	N 48° 22,63 E 110° 16,23
7	Хиргисүүр Хиргисүүр маягийн жижиг булш	1 1	N 48° 22,84 E 110° 16,41
8	Дугуй хүрээтэй хиргисүүр тахилын байгууламжтай	2	N 48° 22,84 E 110° 17,29
9	Дугуй хүрээтэй хиргисүүр	1	N 48° 22,20 E 110° 15,74







ТАХИЛГАТ БИҮНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ






10	Том дугуй хүрээтэй тахилын байгууламж бүхий хиргисүүр	1	N 48°22,00 E 110°16,05
11	Ухаж тоносон хүрээгүй дугуй хиргисүүр	1	N 48°22,42 E 110°16,56
12	Хүрээгүй дугуй хиргисүүр	1	N 48°22,53 E 110°16,75
13	Хүрээгүй жижиг хиргисүүр	12	N 48°22,46 E 110°17,42
14	Дугуй жижиг хиргисүүр	7	N 48°25,15 E 110°17,32
15	Дугуй хүрээтэй тахилын байгууламж бүхий хиргисүүр	1	N 48°22,25 E 110°16,89
16	Дугуй хүрээтэй хиргисүүр	1	N 48°22,25 E 110°16,85
17	Хүрээгүй дугуй хиргисүүр	1	N 48°22,25 E 110°15,97
18	Хүрээгүй дунгуй хиргисүүр	1	N 48°22,55 E 110°17,79
19	Зүүн урдуураа хагас дугуй хүрээтэй тахилын байгууламжтай хиргисүүр	1	N 48°22,55 E 110°17,79
	Бүгд	39	

2. Дөрвөлжин булш

Д/д	Дурсгалын нэр	Тоо пирхэг	Байршил
1	Дөрвөлжин булш	7	N 48° 22' 39.6 E 110° 18' 9.0
2	Дөрвөлжин булш	6	N 48° 22' 7.8 E 110° 19' 57
3	Дөрвөлжин булш	16	N 48° 25' 0.0 E 110° 17' 51
4	Тахилын байгууламжтай дөрвөлжин булш	2	N 48° 21' 58.2 E 110° 15' 45.6
5	Дөрвөлжин булш	1	N 48° 22' 10.2 E 110° 15' 29.4
6	Дөрвөлжин булш	5	N 48° 22' 39.6 E 110° 18' 9.0
7	Дөрвөлжин булш	1	N 48° 22' 43.2 E 110° 16' 18.
8	Дөрвөлжин булш	14	N 48° 22' 43.8 E 110° 17' 1.2
9	Дөрвөлжин булш, гонзгой дөрвөлжин булш	9	N 48° 22' 55.2 E 110° 17' 17.4



ТАХИЛГАТ БИҮНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ






10	Дөрвөлжин булш	4	N 48° 22' 12.0 E 110° 15' 44.4
11	Дөрвөлжин булш	2	N 48° 22' 0.0 E 110° 16' 3
12	Дөрвөлжин булш	4	N 48° 22' 23.4 E 110° 16' 7.8
13	Дөрвөлжин булш	7	N 48° 22' 26.4 E 110° 16' 5.4
14	Дөрвөлжин булш	8	N 48° 22' 27.6 E 110° 16' 12
15	Дөрвөлжин булш	15	N 48° 22' 25.2 E 110° 16' 33.6
16	Дөрвөлжин булш	1	N 48° 22' 31.8 E 110° 16' 39.6
17	Дөрвөлжин булш	15	N 48° 22' 31.8 E 110° 16' 45.0
18	Дөрвөлжин булш	12	N 48° 22' 30.6 E 110° 17' 6.0
19	Дөрвөлжин булш	8	N 48° 22' 27.6 E 110° 17' 25.2
20	Дөрвөлжин булш	4	N 48° 25' 9.0 E 110° 17' 19.2
21	Дөрвөлжин булш	3	N 48° 22' 15 E 110° 16' 51.0
22	Дөрвөлжин булш	5	N 48° 22' 15 E 110° 15' 58.2
23	Дөрвөлжин булш	1	N 48° 22' 13.8 E 110° 16' 39.6
24	Дөрвөлжин булш	4	N 48° 22' 33 E 110° 17' 47.4
	Бүгд	153	


3. Хүрлийн үеийн дугуй булш

Д/А	Дурсгалын нэр	Тоо ширхэг	Байршил
1	Дугуй булш	14	N 48°25,00 E 110°17,85
2	Дугуй жижиг булш	4	
3	Дугуй булш	8	N 48°22,72 E 110°16,30
4	Зүүн талдаа тахилын байгууламжтай булш	1	N 48°22,84
	Тахилын чулуугүй жижиг булш	1	E 110°16,41
	Урдаа босоо чулуутай булш	1	



ТАХИЛГАТ БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ







5	Чулуун дараастай дугуй булш	5	N 48°22,73 E 110°17,02
6	Чулуун дараастай жижиг булш	6	N 48°22,20 E 110°17,74
7	Чулуун дараастай дугуй булш	4	N 48°22,00 E 110°16,05
8	Дугуй булш	1	N 48°22,42 E 110°16,56
9	Хүрлийн байж болох жижиг булш	2	N 48°22,29 E 110°16,80
	Бүгд	47	

4. Түрэг болон түрэг хэлбэрийн булш

Д/д	Дурсгалын нэр	Тоо ширхэг	Байршил
1	Гонзгой дөрвөлжин хэлбэртэй булш Түрэг булш	1 2	N 48°22,92 E 110°17,29
2	Түрэг маягийн булш	2	N 48°22,39 E 110°16,13
3	Түрэг маягийн булш	1	N 48°25,15 E 110°17,32
4	Түрэг маягийн дөрвөлжин хашлага бүхий тахилын байгууламж	3	N 48°25,15 E 110°17,41
5	Түрэг маягийн булш	1	N 48°22,25 E 110°16,85
	Бүгд	10	

1.3 Дөрвөлжин булшны хөшөө чулуу

2009-2010 оны бүртгэл судалгааны ажлын явцад Биндэр уулын урд энгэрийн Чунсалын хавтгай болон Дуган хадны өвөрт орших дөрвөлжин булшны зүүн этгээдэд 20-30 м зайд босгосон хөшөө чулууд анхаарал татаж байлаа. Бид Биндэр уул орчмоос нийт 20 гаруй хөшөөтэй булш бүртгэснээс гадаргуу дээрээ дүрс тэмдэгтэй 9 хөшөө чулуу бүртгэсний гурвыг нь давтан бүртгэж, зургааг нь шинээр илрүүлэн бүртгэсэн болно. Академич Х.Пэрлээ абугайн 1977 онд хэвлүүлсэн «Хүн чулуун хөшөөний үүсэл хувьслын тухай» [Пэрлээ, 1977:14-19] гэх өгүүлэлд Биндэр уулын орчмоос олж тойм зургийг нь нийтлүүлсэн зургаан хөшөө чулуунаас бид гурвыг нь олоогүй болно. Х.Пэрлээ дээрх өгүүлэлдээ Монголчуудын уугуул нутаг Онон, Хэрлэн, Туул голын савд тэр дундаа Биндэр уулын орчимд хийсэн



судалгаандаа үндэслэн дөрвөлжин булшны нэгэн бүлэгт буюу нэгэн булшны талбайд 1-3 хүртэл хүн төрхөт (антропоморф) байгааг анзааран үзээд тэдгээр хөшөөг хийц хэлбэрийн өөрчлөлтөөр нь Монгол булшны хүн чулууны хөшөөний үүсэл хувьсалд холбогдуулан авч үзэх санал гаргаад "хүн төрхөт хөшөөг бүлэг дөрвөлжин булшны голлох нэгэн булшинд их төлөв босгодог нэгэн нийтлэг зан үйл байжээ" гэсэн байна [Пэрлээ, 1977:14,18].

Дөрвөлжин булшны зүүн талд хөшөө чулуу босгосон талаар цөөнгүй судлаачид нягтлан үзэж өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Өвөр Байгалийн дөрвөлжин булшийг дагнан судалсан Н.Н.Диков хүрлийн үеийн дөрвөлжин булшинд хөшөө чулуу босгосон нь элбэг тохиолддог болохыг дурдаад эдгээр чулууг «харуул чулуу» гэж нэрлэдэг гээд өвөг дээдсийн шүтлэгтэй холбоотой «овгийн буюу гэр бүлийн бурхан» бөгөөд «ромын пенат ба грекийн нас барагсдын оромжийг хамгаалдгийн адил талийгаачдын гэрийг (булш Ц,Т) хамгаалах үүрэгтэй [Төрбат, 2000:291] гэж үзжээ. Археологич Д.Наваан эдгээр хөшөөдийн тухай «Дорнод Монголын хүрэл зэвсгийн үе» бүтээлдээ «... булшны зүүн талын булан, өнцөгт ханын бусад чулуунаас өндөр чулуу зоох, эсхүл булшнаас нэлээд зайтай боловч мөн л зүүн талд нь шон, хөшөө босгох ёс заншил зэрэг нь зүг эрхэмлэхтэй холбогдон гарчээ» [Наваан, 1975:131] хэмээсэн байдаг. Буриадын археологич А.Д.Цыбиктаров Өвөр байгал ба Монголын дөрвөлжин булшийг судалж үзээд он цагийн хувьд хожуу хүрэл буюу МЭӨ XIII-VIII зуун түрүү скифийн үе буюу МЭӨ VIII-VI зуун хэмээн хувааж үзсэн бөгөөд хоёр дахь үе буюу Ацайн үед холбогдох булшинд хөшөө чулуу бүхий булшийг холбогдуулан үзсэн байдаг [Цыбиктаров, 1998:114-115, рис 96]. Мөн археологич Ц.Төрбат булшинд хөшөө босгох зан үйлийг Евразийн нүүдэлчдийн морь шүтэх үзэлтэй холбон угсаатны зүйн мэдээг бичгийн сурвалжаар баяжуулан тайлбарлаж [Төрбат, 2000:290-296] «... Евразийн олон угсаатнууд тусгайлан зоосон шонг «сэргэ» гэж морины уяа-шонтой адилтган нэрлэдэг байсан бөгөөд Монгол буриадуудын дунд «сэргэ»-г онцгойлон шүтдэг байжээ. Энэ мэт хэрэглэгдэхүүнүүдээс булшинд босгодог шон «сэргэ»-гийн



үүрэг тодорхой харагдаж байгаа аж. Иймд «нөгөө ертөнцтэй харьцах дөт шууд зам болох «сэргэ»-д уясан морь эзнээ саадгүй хүргэх ёстой гэсэн утга санааг эртний булшийг бүтээгчид агуулж байсан байна» гэжээ. Энэ нь «хүрлийн үеэс булш оршуулгад «сэргэ» босгох зан үйл уламжлагдсаар хүннү, түрэг, монголын үед ирсэн» хэмээжээ [Төрбат, 2000:294-295; Амартүвшин, 2003:86]. Бид сүүлийн 10-аад жил Монгол орны зүүн, төвийн бүс нутагт явуулсан археологийн хайгуул, судалгаагаар зүүн талдаа хөшөө чулуу бүхий олон тооны дөрвөлжин булшийг шинээр бүртгэж, өөрсдийн санал, таамгийг дэвшүүлж байсныг дурдъя [Даваацэрэн, Анхсанаа, Мижиддорж, 2010:32-36].

Сүүлийн жилүүдэд тодруулбал, 2013 оноос бүс нутгийн хүрлийн үеийг дагнан судалж байгаа судлаачид дөрвөлжин булшны хөшөө чулуудыг тухайлан шинжлээд өөр өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Читад малтсан Анхобае-7-д дөрвөлжин булшнууд 6, 6-аар хосоор хойноос урагш эгнэн байрласан байхад тэдний дунд нэг том харуул чулуу гозойлгосон байна. Харуул чулууг хэлбэрийн хувьд хоёр хувааж болох ба эхнийх нь хүн дүрст болон түүнтэй төстэй, дараах нь наран тамга мэт зурагтай хөшөө гэж болно. Харуул чулууг буган хөшөөний айд багтаан үзэх нь зөв шийдэл болох ба ингэж үзвэл Өвөрбайгалын буган хөшөөд олон тоотой болох юм [Дашилхамаев, 2012, с. 60-68]. Гэсэн бол А.Д.Цыбиктаров дөрвөлжин булшинд буган чулууг барилгын материал болгон ашиглахдаа тодорхой зохион байгуулалтгүй (булан, хашлага, харуул чулуу болгох, нүх таглах г.м) байсан нь тэд хоорондоо дайсагналцаж байсны илрэл болох боловч эцэстээ «...дөрвөлжин булшны эздийн аль нэг хэсгийн харилцаа хэвийн болсон нь буган чулууг хөшөө болгож ашиглах болсноор харагдана. Энэ нь Ингода, Чиндал, Анхабай зэрэг голын хөндий дэх дөрвөлжин булшны зарим дурсгалуудад Монгол, Өвөрбайгалын хэлбэрийн буган чулуутай төслөг хөшөөд байгаа явдал болно» [Цыбиктаров, 2016:294-301] гэж тайлбарлажээ.

Археологич С.Өлзийбаяр «Хиргисүүр-буган хөшөөний соёлын задралын үед тэдний зарим хэсэг дөрвөлжин булшны соёлыг хүлээн авах болсны нэгэн илрэл нь Дорнод Монгол, Зүүн




Өвөрбайгалын нутагт буй буган хөшөө бүхий дөрвөлжин булш болно. Энэ бүс нутгийн дөрвөлжин булшинд босгосон буган хөшөө нь Төв Монголынхтой адил сонгодог хэлбэртэй бус харин орон нутгийн харуул чулууны шинжийг илэрхийлсэн бугын дүрсгүй хуурмаг хүн дүрст болон нутгийн онцлогтой бугын дүрс бүхий хөшөө чулууны хэлбэртэй болж төлөвшсөн гэж үзэж байна» хэмээн тэмдэглэжээ. Дээрх судлаачид хөшөө чулуу босгох болсон шалтгааны археологийн соёл, угсаа гарвалийн үүднээс илүүтэй хөндөж үзсэн байна [Өлзийбаяр, Хасархүү, 2018:196-199].

Түүнчлэн, дээрх хөшөө чулуун дээр дүрсэлсэн тамга тэмдгийн дүрслэл Монгол орны хадны зургийн дурсгал болон тамга тэмдэг бүхий хад чулуун дээр тааралдаагүй нь сонирхолтой юм. Харин үүнтэй төсөөтэй тамгыг Унгарчууд өрхийн болон овгийн тамга болгон хэрэглэдэг талаар академич Х.Пэрлээ «Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь» бүтээлдээ тэмдэглэсэн [Пэрлээ, 2012:165] байна.

Энэ мэтчилэн дөрвөлжин булшны зүүн талд босгосон байдаг хөшөө чулуудын үүрэг зориулалтын талаар судлаачдын байр суурь харилцан адилгүй байгаа нь уг дурсгалыг тусгайлан давтан судлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Тахилгат Биндэр уулын өврөөр орших дөрвөлжин булшны хөшөө чулууд дээрх шанаган тамга мэт дүрсний үүсэл, уламжлал, утга агуулгын талаар улируулан судлах нь дөрвөлжин булшны судлалд цаашлаад Төв Азийн хүрлийн үеийн археологийн соёлын онцлог, харилцан хамаарал, хөгжил бууралтыг судлахад чухал эх сурвалж болох юм.

1-р хөшөө чулуу:
Шаргал өнгийн
боржин чулуугаар
үйлдсэн, дээд хэсэгт
нарийн зураасаар
тойруулан хүзүүний
заагийг гаргасан,
баруун талын нарийн
хэсэгт 18 см голчтой
дугуй цагариг




1-р хөшөө чулууны гар зураг



сийлсэн байна. Хөшөө нь 38 см урттай, 20 см орчим өргөнтэй, 10 гаруй см зузаантай доод талын хэсэг нь зааг гарч хагарсан байна.

2-р хөшөө чулуу:

Саарал өнгийн нарийн ширхэгтэй боржин чулуугаар үйлдсэн, урд талын өргөн хэсэгт нарийн зураасаар хүзүү болон их биеийг, ар талын өргөн хэсгийн




2-р хөшөө чулууны гар зураг

голд, дээд талдаа бөөрөнхийтэй, доош үргэлжилсэн урт нарийн зураас сийлсэн байна. Хөшөө нь 40 см урттай, 26 см өргөнтэй 15 см байн. Мөн уг хөшөө баруун талдаа дээрээс доош хөндлөн цуурсан байдалтай байна.

3-р хөшөө чулуу:

Шаргал өнгийн боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн хэсэгт баруун дээд талаас зүүн доош чиглэсэн 13 см урт нарийн зураастай, ар талын




3-р хөшөө чулууны гар зураг

өргөн хэсгийн дээд талд бөөрөнхийтэй үүнээс доош үргэжилсэн урт нарийн зураас сийлсэн бөгөөд түүний дээр хөндлөн дээрээс доош цуварсан 4 зураастай шанага маягийн тамга сийлсэн байна. Хөшөө нь 30 см урттай, 19 см өргөнтэй, 11 см зузаантай байна.

4-р хөшөө чулуу:

Хөх саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн, хоёр талын өргөн хэсэгт дүрслэл үгүй, харин баруун талын нарийн хэсгийн дээд талд




4-р хөшөө чулууны гар зураг



бөөрөнхийтэй, үүнээс доош үрэгжилсэн урт нарийн зураас сийлсэн бөгөөд түүний дээр хөндлөн дээрээс доош 6 зураас эгнүүлэн сийлсэн шанага маягийн тамгатай сийлсэн. Мөн зүүн талын нарийн хэсэгт дээд талдаа бөөрөнхийтэй, үүнээс доош үргэлжилсэн урт нарийн зураас сийлсэн бөгөөд түүний дээр хөндлөн дээрээс доош эгнүүлэн 5 зураас сийлсэн, өмнөх тамгыг бодвол хэмжээний хувьд арай урт юм. Хөшөө нь 36 см урттай, 24 см өргөнтэй, 14 см зузаантай байна.

5-р хөшөө чулуу:

Хүрэн улаан өнгийн боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн тал дээр хүзүү болон их биеийг заагласан урт нарийн зураасыг хонхойлгон сийлсэн




5-р хөшөө чулууны гар зураг

бөгөөд үүнээс доор үргэлжлүүлэн гурвалжин дүрслэл гаргасан байна. Мөн хөшөөний ар талын өргөн хэсэгт дээд талдаа бөөрөнхийтэй, үүнээс доош үргэлжилсэн урт нарийн зураас сийлсэн бөгөөд түүний дээр хөндлөн дээрээс доош эгнүүлэн 5 зураастай шанага маягийн тамга дүрсэлсэн байна. Хөшөө нь 35 см урттай, 20 см өргөнтэй, 16 см зузаантай байна.

6-р хөшөө чулуу:

Шаргал өнгийн боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн тал дээр хүзүү болон их биеийг заагласан урт нарийн зураасыг хонхойлгон сийлсэн




6-р хөшөө чулууны гар зураг

бөгөөд түүний зүүн үзүүрээс баруун дээш ташуу зураас татсан байна. Мөн хөшөөний ар талын өргөн хэсэгт дээд талдаа бөөрөнхийтэй, үүнээс доош үргэлжилсэн урт нарийн зураастай шанага маягийн тамга сийлсэн байна. Хөшөө нь 48 см урттай, 30 см орчим өргөнтэй, 21 см урттай байна.




7-р хөшөө чулуу: Шаргал өнгийн нарийн ширхэгтэй боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн тал дээр хүзүү болон их биеийг заагласан урт нарийн зураасыг хонхойлгон сийлсэн бөгөөд үүний дээд талд хагас дугуйрсан тэмдэг сийлсэн байна. Мөн хүзүүний



7-р хөшөө чулууны гар зураг

зураасны доод талд доош чиглэсэн үзүүртэй гурвалжиндуу дүрс сийлсэн байна. Хөшөөний ар талын өргөн хэсэгт дээд талдаа бөөрөнхийтэй, үүнээс доош үргэлжилсэн урт нарийн зураастай, шанага маягийн тамга сийлсэн байна. Хөшөө 80 см өндөртэй, 30 см өргөнтэй, 18 см зузаантай байна.

8-р хөшөө чулуу: Саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн тал дээр хүзүү болон их биеийг заагласан урт өргөн зураасыг хонхойлгон сийлсэн бөгөөд үүний дээд талд тасалсан урт нарийн зураасыг сийлсэн,




8-р хөшөө чулууны гар зураг

эдгээрийн дээд талд баруун дээд хэсгээс зүүн доош хандсан зураастай байна. Мөн хүзүүний өргөн зураасны доод талд доош чиглэсэн үзүүртэй гурвалжин тэмдэг сийлсэн байна. Хөшөөний ар талын өргөн хэсэгт дээд талдаа бөөрөнхийтэй, үүнээс доош үргэлжилсэн урт нарийн зураастай, шанага маягийн тамга сийлсэн, түүний доор 9 дөрвөлжин товгортой өргөн бүс дүрсэлсэн байна. Хөшөө нь 50 см уртай, 30 гаруй см өргөнтэй, 20 см бөгөөд баруун зүүн талын нарийн хэсэгтэй цуурсан байна.



9-р хөшөө чулуу: Хүрэн өнгийн боржин чулуугаар үйлдсэн, урд зүгт хандсан өргөн тал дээр хөндлөн 3 урт нарийн зураас сийлсэн бөгөөд үүний дээд талд, хөшөөний баруун дээд буланд 10 см голчтой дугуй тэмдэг дүрсэлсэн байна. Хөшөө нь 50 орчим см урттай, 32 см өргөнтэй, 24 см зузаантай байна.



10-р хөшөө чулууны гар зураг

1.4 Үзүүр цохионы хадны зураг

Батширээт сумын төвөөс урагш 47 орчим км, Биндэр уулын зүүн хойд талд Өглөгчийн голын хойд биед оройгоороо дэллэсэн хадтай Хурхын хөндий рүү түрсэн үзүүрийг нутгийнхан "Үзүүр цохио" гэдэг. Эндхийн хад чулууны гадаргуу дээр янз бүрийн хэлбэр хэмжээтэй тамга, тэмдгүүд, адуу, хүн, бугын сийлмэл зургууд таруу байдалтай байдаг.



Үзүүр цохио

Үзүүр цохионы хадны зургийг анх 1963 онд А.Ийсл, Н.Сэр-Оджав нарын удирдсан Монгол-Чехословакийн хамтарсан шинжилгээний анги Хэнтий аймгийн умард хэсгийн нутгаар хайгуул судалгаа хийх явцдаа илрүүлэн олж зарим зургийг нь 1965 онд эрдэм шинжилгээний тодорхойлолт, гэрэл зургийн хамт нийтлүүлжээ [Limur Jisl нар 2003: 423].



1975 онд Монголын археологич Д.Дорж, Зөвлөлтийн эрдэмтэн Э.А.Новгородова нар «Монголын хадны зураг» бүтээлдээ Үзүүр цохионы хадны зургийн тухай товч мэдээ оруулж хуулбар зургийг нь хавсарган нийтэлжээ [Дорж, Новгородова 1975: 36]. Академич Д.Цэвээндорж 1999 онд хэвлүүлсэн нэгэн сэдэвт бүтээлдээ "Үзүүр цохионы орчмоос олдсон 200 гаруй тамга тэмдгүүд нь Рашаан хадны орчмын тамга тэмдгүүдтэй хийсэн арга барил, хэлбэр төрхөөрөө ижил төстэй болох"-ыг тэмдэглэсэн байна [Цэвээндорж 1999:71].

Үзүүр цохионы хадны зургийн талаар 1999 онд хэвлэсэн «Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал» сэдэвчилсэн лавлах, 2006 онд хэвлэгдсэн «Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт» номонд Г.Энхбат бэсрэг тодорхойлолт бичиж нийтлүүлсэн [Монгол., 1999:58-59; Монгол., 2006:56] байна.



Үзүүр цохионы хадны зураг

Үзүүр цохионы хадны зургийн дотор цуван зогссон шавхруун биетэй, эгц шулуун хөлтэй зогсож буй адууг хүн хөтөлсөн буйгаар сийлсэн зураг, мөн соотон чихтэй, урт шулуун хөлтэй, богино годгор сүүлтэй цэгц биетэй цуван зогссон хоёр адууг нэг хүн хөтөлсөн байдлаар тус тус дүрсэлсэн байдаг бөгөөд энд мөн баавгайн сарвуу мэт тамга бий. Энэ зургийг судлаачид хүрлийн үед хамаатуулан үздэг.

Үзүүр цохионы хадны зургийн түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдлыг нь харгалзан Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор аймгийн хамгаалалтад байх



түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад, 2008 оны 175 дугаар тогтоолоор улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад тус тус оруулан баталсан байдаг.

1.5 Хажуу нуурын буган чулуун хөшөө

Батширээт сумын төвөөс урагш 45 орчим км, Биндэрийн Рашаан хаднаас зүүн хойш 7 орчим км зайд Олон нуурын хойд бие, Хажуу нуурын хойд дэнж дээр хоёр буган чулуун хөшөө, 14 дөрвөлжин булш бий.

Энэхүү хоёр буган чулуун хөшөөг анх Х.Пэрлээ, Д.Цэвээндорж нарын бүрэлдэхүүнтэй Гурван голын шинжилгээний анги 1970-аад оны дунд үед олж илрүүлсэн байдаг. Анх олдохдоо унасан байсныг нэр дурдсан судлаачид босгосон ажээ. 1981 онд Зөвлөлтийн эрдэмтэн В.В.Волков «Монголын буган чулуун» хэмээх номондоо товч тодорхойлолт гар зургийн хамт нийтэлжээ [Волков, 2002:95-96]. Хожим 1999 онд «Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал» сэдэвчилсэн лавлах болон 2006 онд «Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт» номонд Академич Д.Цэвээндорж бэсрэг тодорхойлолт нийтлүүлсэн [Монгол.,1999; Монгол., 2006:78] байна. 2008 онд эдгээр буган чулуун хөшөөдийг Соёлын өвийн төв, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хамтарсан шинжилгээний багийн судлаачид хэмжилт хийн баримтжуулж улсын бүртгэлд авсан [Даваацэрэн, 2009:52] байна.

1-р буган хөшөө Зэрэгцсэн хоёр хөшөөний баруун талд нь оршино. Энэхүү буган чулуун хөшөөг элсэн боржин чулуугаар үйлдсэн бөгөөд өндөр нь 2.5 м, өргөн нь 0.31 м, зузаан нь 0.41 м юм. Хөшөөг тойруулан 6-7 бугыг их биеэр нь цоолборлон сийлсэн бололтой байна. Хөшөөний гадаргуу нар салхинд ихээхэн элэгдэж зарим хэсэг нь холцорч унасан учир бусад дүрслэл нь харагдахгүй болж баларчээ.



1-р буган хөшөө



2-р буган хөшөө: Зэрэгцсэн хоёр хөшөөний зүүн талд оршино. Энэхүү буган чулуун хөшөөг мөн л элсэн занар чулуугаар үйлдсэн бөгөөд нөгөө хөшөөгөө бодвол дүрслэлээ харьцангуй сайн хадгалж үлдсэн байна. Хөшөө нь 2.3 м өндөр, 0.42 м өргөн, 0.30 м зузаан юм. Хөшөөний урагш харсан талд ямар нэг дүрслэл мэдэгдэхгүй байна. Хөшөөний баруун талын дээд хэсэгт том жижиг 2 цагираг, түүний доогуур шулуун зураас татаж, түүний доод хэсэгт 3 бугыг зүүн дээш тэмүүлж байгаагаар бүх биеийн хэсгийг нь цоолборлон дүрсэлжээ. Хөшөөний ар талын дээд хэсэгт 4 иштэй онгин тамгыг дүрсэлсэн байх бөгөөд түүний доод хэсгээр хөшөөг бүхэлд нь ороосон шулуун зураас байна. Энэ талд өөр ямар нэг дүрс байхгүй байна. Хөшөөний зүүн талын баруун дээд буланд 1 дугуй, түүний доогуур шулуун зураас, түүний доод хэсэгт 4 бугыг гэдрэг харсан байдлаар баруун дээш тэмүүлж байгаагаар бүх биеийг цоолборлон дүрсэлжээ. Хамгийн доод талын бугын хондлойг дайруулан шулуун зураас татсан байна.



2-р буган хөшөө



Хажуу нуурын буган хөшөө



Хөшөөний гадаргуу дээр дүрсэлсэн бугыг бүгдийг нь загварчлан дүрсэлсэн байх бөгөөд дээд доод хоёр хэсгээр нь хөшөөг бүтэн тойруулан шулуун зураас татсан байна. Хөшөөнд зэр зэвсгийн болон бусад зүйлс мэдэгдэхгүй байна.

Хажуу нуурын буган чулуун хөшөөд нь одоогоор Монгол улсын нутаг дэвсгэрээс илэрч мэдэгдээд байгаа 1240 орчим буган чулуун хөшөөний хамгийн зүүн захад оршиж байгаагаараа онцлог юм. Эдгээр буган чулуун хөшөөдийг Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад тус тус оруулсан байдаг.

1.6 Өглөгчийн хэрэм

Хэнтий аймгийн Батширээт сумын төвөөс баруун урагш 45 орчим км, Баян гол Өглөгчийн голд нийлэх бэлчирээс 8-10 км зайд, Дайчин уулын энгэрт "Өглөгчийн хэрэм" хэмээх чулуун хэрэм бий.



Өглөгчийн хэрэм

Тус хэрмийг урт хугацаанд ул суурьтай нарийн шинжиж судалсан ажил өнөөг хүртэл тогтвортой хийгдээгүй байна. Гэхдээ олон судлаач хэрмийн дотор гаднаас олдсон олдворуудад үндэслэн өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Өглөгчийн хэрмийг 1926 онд үзсэн Зөвлөлтийн эрдэмтэн С.Кондратьев




«XII-XIII зууны үеийн нум сумчдын бэхлэлт цайз байсан болов уу» гэсэн санал дэвшүүлсэн байдаг бол Х.Пэрлээ хэрмийн дотроос олдсон ваар савны хагархай дээрх хээ чимгийг үндэслэн «киданы үед холбогдоно» хэмээн тогтоосон [Пэрлээ 2001; 205] байдаг. Түүний энэ саналыг 1990-ээд оны эхээр тус бүс нутагт ажилласан «Гурван гол»-ын шинжилгээний анги, 1994 онд Өглөгчийн хэрэмд зарим хэмжилтийн ажил хийсэн «Мон-Сол» төслийн судлаачид дэмждэг юм.

2000 оны эхээр тус газарт Монгол-Америкийн хамтарсан «Чингис хаан» төслийн шинжилгээний анги Өглөгчийн хэрмийг судалж ихэс дээдсийн оршуулгын газар мөн хэмээн дүгнэсэн байдаг. Энэ шинжилгээний анги 2002 онд хэрмийн дотор малтлага судалгааны ажил хийж өөр өөр цаг үед холбогдох булш илрүүлэн олсон байна. Мөн шалны ханзны байгууламжийг малтан ил гаргажээ [Өлзийбаяр 2003:76-81]. 2008 онд Өглөгчийн хэрмийг Соёлын өвийн төв, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хамтарсан шинжилгээний багийн судлаачид хэмжилт хийн 2850 орчим м урттай чулуун байгууламж болохыг нь тогтоон баримтжуулан улсын бүртгэлд авсан [Даваацэрэн 2009:52] байна.

Бид 2009 онд хэрмийн бүтэц, зохион байгуулалт болон хэрмийн дотор хийсэн археологийн малтлагын талбайтай танилцаж гэрэл зургаар давтан баримтжуулав.

Чулуун хэрэм. Хэрмийг уулын энгэрийг хөвөөлүүлж тойруулан чулууг нямбайлан өрж барьж байгуулжээ. Зарим хэсэг нь уулын цавчим өндөр хад чулууг дамналдуулан өрөгдсөн байдаг. Эдүгээ хэрмийн чулуун өрлөгийн ихэнх нь хүн мал, байгалийн нөлөөллөөс болж их бага хэмжээгээр нурсан байна. Хэрмийн өмнө талд үүд бий. Ханын өндөр харилцан адилгүй бөгөөд дунджаар 2.5 орчим м өндөр аж. Хэрмийн зүүн хойд тал нуралт багатай хэсэгтээ 3.2 орчим м өндөр, 2.0 орчим м



Чулуун хэрмийн дэвсгэр зураг



Өглөгчийн хэрэм

зузаантай байв. Хэрмийн нийт уртыг судлаачид 2800 орчим м, 3000 м, 3200 м, 3500 гэх мэт зөрөөтэй тэмдэглэсээр ирсэн. 2008 онд Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачид бүтэн тойрч үзэхэд 2850 орчим м болж байжээ. Хэрмийн голоор баруун хойноос зүүн урагш чиглэсэн ус зайлуулах зориулалт бүхий шуудуу татсан байна.

Хэрмийн дунд алсаас тод харагдах гозгор хадан цохиог нутгийн ардууд «Чингисийн морины уяа» хэмээн домоглон ярьдаг.

Археологийн малтлага хийсэн талбай.

Хэрмийн голд орших хад чулуутай дэвсэг дээр Монгол-Америкийн хамтарсан шинжилгээний ангийн 2001-2006 он хүртэл археологийн малтлага судалгааны ажил хийсэн юм. Талбайг банз, зүсмэл шургаагаар хашиж хамгаалсан боловч хугарч унажээ. Энд 3-4 газарт сууц халаах ханзны зохион байгуулалт бүхий эгнүүлэн өрсөн чулуунууд байв. Харамсалтай нь олон зуун жил газрын хөрсөн дор түүхэн үнэ цэнээ хадгалан байсан дурсгалыг ил орхисноос болж хүн, мал амьтны хөлөөр анхны хэв төрхөө алдаж чулууд нь тарж бутран хөглөрсөн байдалтай болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Өглөгчийн хэрмийг улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад тус тус оруулсан.

1.7 Баянголын амны хүн чулуун хөшөө

Батширээт сумын төвөөс урагш 30 гаруй км, Баянголын аманд Улаан үзүүрийн зүүн урд хөндий, Ханхарын давааны өвөрт нэгэн



хүн чулуун хөшөө бий. Энэ нь Баянголын хойд эрэг дээр буюу хойд өргөргийн 48°27'013" зүүн уртрагийн 110°14'236" солбицолд оршино. Нутгийн ард иргэдийн хэлж байгаагаар уг хүн чулуун хөшөө мал амьтны нөлөөгөөр байнга ойчдог байсан гэнэ. Харин сүүлд хэсэг хүмүүс босгож ёроолыг нь чулуудаар сайтар чигжиж өгсөн тул ойрын хэдэн жил унаж ойчоогүй байгаа ажээ.

Баянголын амны хүн чулуун хөшөөг анх академич Х.Пэрлээ, нэрт газарзүйч О.Намнандорж нар үзэж танилцан товч тэмдэглэл хийж авсан байдаг. Түүнээс хойш 1991 онд Монгол-Японы хамтарсан «Гурван гол»-ын шинжилгээний ангийн судлаачид гэрэл зургаар баримтжуулж тайландаа оруулжээ. Бид энэхүү хүн чулуун хөшөөнд хэмжилт хийн гар болон гэрэл зургаар баримтжуулж авсан болно.



Баянголын амны хүн чулуун хөшөөний гэрэл ба гар зураг

Баянголын амны хүн чулууг саарал өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар урласан бөгөөд хавтгайлж зассан хэсэгт зөвхөн хүний нүүрний эд эрхтнийг дүрсэлжээ. Хүний нүүрний эд эрхтнийг хонхойлж ухах аргаар гаргасан харагдана. Хөшөөний гадаргуу дээр өөр ямар дүрс, зургийн зүйл үгүй юм. Хөшөөнөөс зүүн тийш 70-аад м зайд зүүн хойш чиглэлтэй эгнэсэн хэдэн тахилын байгууламж байна. Эдгээр нь хавтгай чулуудыг газрын хөрстэй тэнцүү байдлаар ирмэглэн суулгаж дөрвөлжин хашлага үйлдсэн хэлбэрээрээ өөр хоорондоо ижилхэн боловч хэмжээний хувьд бага зэргийн ялгаатай ажээ.




Баянголын амны хүн чулуун хөшөөний дүрслэл, түүний дэргэдэх чулуун байгууламжийн зохион байгуулалтаас үзвэл, Түрэгийн үеийн шинжийг бүрнээ агуулсан дурсгалууд болох нь тодорхой байна.

1.8 Дуган хадны өврийн чулуун зам

Биндэрийн овоо руу өгсдөг энгэрт, академич Х.Пэрлээгийн малтан судалсан дөрвөлжин булшнуудын баруун талд Дуган хадны урд энгэрт орших Биндэр нуурын зүгт түрж тогтсон хадан хошууны үзүүрээс нуурын овоог чиглэсэн чулуун зам бий. Энэ дурсгалыг өмнө нь Х.Пэрлээ, Д.Наваан, Х.Лхагвасүрэн нарын зэрэг археологич эрдэмтэд үзэж байсан гэх боловч тэдний бичиж нийтлүүлсэн ямар нэг хэрэглэгдэхүүн бидэнд олдсонгүй.

Энэ чулуун замыг 3 хэсэг газраар машин зам дайрч сэтэлсэн байна. Бусад хэсгийн замын том жижиг чулууд эдүгээ маш их хөдөлгөөнд орж нааш цааш тарсан ч ерөнхийдөө нэг шулуунд оршиж байсан хэлбэрээ хадгалсан байна. Нуурын овооны орчмын чулууд тарж бутран ихээхэн цөөрсөн харагдана. Магадгүй энэ хэсгийн чулуудыг ашиглан нуурын овоог босгосон ч байж болох юм.



Дуган хадны өврийн чулуун зам

Чулуун замын чулуудын өнөөгийн байрлал нь энэхүү дурсгалын анхны хэлбэрийг тодорхойлж хэлэхийн аргагүй болтлоо тарж бутарсныг өмнө өгүүлсэн. Бидний таамаглалаар бол энэхүү зам анх эмх цэгцтэй өрсөн бага хэмжээний чулуун өрлөг бүхий хэрэм байсан байж болох талтай юм. Харин энэхүү замыг чухам юунд зориулж ийнхүү барьж байгуулсан болохыг тааж хэлэх аргагүй юм. Цаашид энэхүү дурсгалыг нарийвчлан судалж тодруулах шаардлагатай.



1.9 Биндэрийн энгэрийн чулуун байгууламж

Биндэр уулын оройн урд талд хэсэг тэгш дэвсэг газар бий. Энд төвдөөр «Ум» гэсэн үсэг сийлсэн 50 орчим см өндөртэй намхан хөшөө чулуу байх ба түүний баруун урд талд хавтгай чулуун шал бүхий хэдэн дөрвөлжин байгууламж бий. Хавтгай чулуудыг газрын хөрсөн дээр шууд дэвсэж байгуулсан тул зарим хэсэг нь хөрсөнд дарагдсанаас харагдахгүй болж чухам хэчнээн ийм байгууламж байгаа, тэр нь ямар хэлбэр хэмжээтэй зэргийг тодорхойлох араггүй болжээ. Ямар боловч уг байгууламжийн хаяа, зах нь тэгш хэмтэй, булан тохойг тэгш өнцөгт байдлаар гаргасан нь нэгэн цагт хүний гараар бүтээгдсэн дурсгал болохыг гэрчилнэ.

Чулуун байгууламжийн өмнө этгээдэд хэсэг чулуун овоолго байна. Энд хавтгай чулууд олон харагдаж байгаа нь дээр өгүүлсэн байгууламжийн чулуудыг хожим энд овоолсон мэт сэтгэгдэл төрүүлж байв. Уг чулуун овоолгын дээр буй хавтгай чулуудын байрлалыг ажиглахад анх энд чулуун дөрвөлжин хайрцаг үйлдсэн нь эдүгээ нурж тарсан бололтой харагдана. Гэхдээ бид ямар нэг чулууг хөндөж уг байгууламжийн бүтэц зохион байгуулалтыг тодорхойлохоор ямар нэг үйлдэл хийгээгүй юм.



Биндэрийн энгэрийн чулуун байгууламж



Өгүүлэн буй хавтгай чулуун дөрвөлжин шал мэт байгууламжийн дунд ганц нэг хотгор хэсэг, баруун зүүн урд хэсэгт булш, эсвэл тахилын байгууламж мэт багавтар чулуун овоолго мэр сэр харагдаж байв. Эдгээрийн гадаад хэлбэр, зохион байгуулалтыг нь ажиглаад шууд онож тайлбарлах боломжгүй байлаа. Энэ хэсэг газарт буй чулуун байгууламжуудын анхны хэлбэр, бүтэц, зохион байгуулалт их бага хэмжээгээр эвдэрсэн тул нарийн тодорхойлох бололцоог бидэнд олгоогүй юм. Харин профессор А.Очир энэхүү байгууламжийг тахилын зориулалтаар барьсан байгууламж болов уу хэмээн таамаглаж байв.

Энэхүү Биндэр уул бол Гурван голын Монголчуудын нутаглаж байсан голомт нутгийн нэг болох нь түүхийн олон сурвалжийн мэдээгээр нотлогддог тул цаашид энэ мэт нууцлаг дурсгалыг нарийвчлан судалж чухам ямар зориулалттай, ямар утга учиртай байгууламж болохыг нь нарийн тогтоох хэрэгтэй юм.



Судалгааны баг



Судалгаа хийж байгаа нь



Хоёрдугаар бүлэг.

РАШААН ХАДНЫ ДУРСГАЛ

2.1 Рашаан хад, түүний орчмын дурсгалыг судалсан байдал

Монгол орны зүүн бүс, Хэнтий аймгийн Батширээт сумын Барх багийн нутагт орших Рашаан хад хэмээн нэрлэгддэг түүх, соёлын дурсгалт газар нь зүүн уртрагийн 110 17' 948", хойд өргөргийн 48 22' 764" далайн төвшнөөс дээш 1115 метрт байрлана.

Энэхүү газрыг нутгийнхан нь Хунт Биндэр, Биндэрийн эрүү, Бидэр хошуу ч гэж нэрлэдэг. Биндэрийн эрүү хэмээн нэрлэсэн нь Хан Хэнтийн нурууны салбар уулсын зүүн урд талын төгсгөл болох Биндэр уулын зүүн урд үзүүрээс Хурхын голын хөндий рүү түрж эрүүдэн шувтарч салан, хэсэглэн салж тогтсон өндөрлөг газар байх хэсэг бүлэг хадыг алсаас харагдах байдлаар нь ийнхүү нэрлэсэн биз ээ. Мөн Биндэр уулын зүүн урд хошуунд тасран байрласан энэхүү хад асга бүхий толгой нь алс холоос зурваслан харлаж, товойж бидэртэн харагдах тул Бидэр хошуу гэж нэрлэсэн бололтой. «Бидэртэн харагдах» хэмээх үгийг монголчууд алс хол газраас гүрвэлзэн, овойж товойн харагдаж буй зүйлийг, ялангуяа чулуу, уул хадыг ийнхүү тайлбарладаг билээ.

Нутгийн ард иргэдийн дунд «Хунт Биндэрийн цахиур» гэх хоршоо үг их хэлэгдэх бөгөөд учрыг сурвалжилбал «Биндэр уулын цахиурыг нутгийн иргэд Да Хүрээнд аваачиж худалдаж чамгүй ашиг хүртдэг байсан бөгөөд дамлагчид уг чулуудыг Биндэрийн цахиур биетэй хэмээн зардаг байжээ.

Нутгийн ард түмэн энэхүү Биндэрийн эрүү хэмээх хадтай хошууны зүүн урагш харсан хадны зуны улиралд шүүрч дуслах усыг тосон авч РАШААН хэмээн нүдээ шавших зэргээр хэрэглэж иржээ. Мөн тэр хавийн хадны хонхорт тогтсон борооны усаар нүүрээ шавшин угааж, нүүрний арьсанд сайн хэмээн хэрэглэж ирсэн байна. Тэрхүү ус дуслах мөргөцөг, түүний орчмын хадан дээр сүг зураг, овог аймгийн тамга



тэмдэг, дүрс, эртний бичээс элбэг байдаг тул тэдгээр дурсгалыг РАШААН ХАДНЫ ДУРСГАЛ гэж эрдэм шинжилгээний ном бүтээлд бичих болжээ.

Зүүн бүс нутаг төдийгүй монгол нутагт Рашаан хад түүний ойр орчимд (1-12 км) байх чулуун зэвсгийн суурин, эртний булш, хадны сүг зураг, тамга тэмдгийн дурсгал, олон төрлийн бичээс, буган чулуу, хүн чулуу, эртний хэрмэн хана зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал нэг дор төвлөрсөн газар маш цөөн байдаг. Мөн энэхүү дурсгалт газар нь зөвхөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар төдийгүй тухайн бүс нутагт амьдарч буй буриад зон олны өвөрмөц соёл, дуу хуур, ёс заншил, ахуй орчин, уламжлалт арга ухаан зэрэг СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН их уламжлалыг тээж агуулсан бүс нутаг юм.

Уг дурсгалын дүрс, тамгануудыг нутгийн ардууд «Адууны мөр», «Морины туурай» гэлцдэг. 1920-иод оны үед энэ нутгийн эртний дурсгалыг сонирхогч Хайдавданзан гэдэг хүн Рашаан хадны тухай мэдээллийг тэр цагийн Судар бичгийн хүрээлэнд ирүүлж байжээ.

Рашаан хад, түүний эргэн тойрон дахь дурсгалыг монголын археологийн шинжлэх ухааны «эцэг» хэмээн нэрлэгддэг, Хөдөөгийн Пэрлээ 1943 оноос анх судлан улмаар тэндхийн хад чулуун дээр сийлэн үлдээсэн тамга, тэмдэг, дүрсийг судлан 1968 онд тэндхийн нэг дор бөөнөөр сийлсэн тамга бүхий чулууг нээн олж, 1976 онд «Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь» нэгэн сэдэвт зохиол бичиж хэвлүүлжээ. Энэхүү бүтээлд Рашаан хадны дурсгалын орчимд байгаа хадан дээрх тэмдэг зурлагыг судлан нийт 400 гаруй тамга тэмдгийн дүрс, сүг зураг байгааг тогтоон эдгээр дүрс, тамга тэмдгүүдийг монгол нутагт зэрэгцэн оршиж байсан олон овог аймгийн хэрэглэж байсан болон Ази, Европ, Америк, Африк тивийн ард түмний дунд тархсан тамга тэмдэгтэй харьцуулан судалж, монгол овог аймаг, үндэстний тамганы талаарх мэдээллийг нэгтгэсэн байна.

Археологич, академич Д.Цэвээндорж «...Энэ орчмоос палеолит, мезолит, неолитын чулуун зэвсгүүд, хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн буган хөшөө, булш, хүннү, кидан, монголчуудын булш олонтаа олддог. Рашаан хаднаа дээд палеолитын үеэс



дундад зууны үе хүртэлх олон үед хамаарах ан амьтан, хүний зургийг цоолборлож, зурж, овгийн хэдэн зуун тамгыг сийлж, орхон, кидан, араб-перс, хятад, түвд, монгол бичгээр хорь гаруй бичээс бичиж үлдээжээ. Эдгээр баримтаас үзэхэд Рашаан хадны орчим нутаг нь палеолитын үеэс дундад зууныг хүртэл түүхийн олон үеийн турш монголын дорнод хэсгийн соёл иргэншлийн нэгэн голомт нутаг байсан бололтой» гэж энэхүү дурсгалт газрын талаар дүгнэсэн байдаг. Мөн тэрээр «Монгол Улсын дорнод хэсгээс Рашаан хад шиг археологийн цогцолбор дурсгал одоо хир илэрч мэдэгдээгүй бөгөөд Рашаан хад нь нэн эртнээс дундад зууныг хүртэл Монголын дорнод хэсгийн соёлын нэгэн төв нутаг байсан гэж» онцолжээ.

Ялангуяа Рашаан хадны чанх дэргэд байх зориуд засаж янзлан, хэлбэр гаргасан байж болох хавтан чулуун дээр сийлсэн үндсэн болон үүсмэл тамга тэмдгийн цуглуулга нь маш өвөрмөц бөгөөд нэг дор тийм олноор янз бүрийн дүрстэй тамга тэмдэг зориуд сийлэн үлдээсэн нь монголд өөр үгүй гэж хэлж болно.

Хавтан чулуун самбар дахь тамга тэмдгийн тухай академич Х.Пэрлээ «... энд олон овог удаа дараагаар үе үе хуралдай зарлан хуралдуулж, хурим ёс хийж, тэр цагийн ёсон заншлаар олон овгийнхон тамгаа сийлэн үлдээдэг байснаас эртний овгуудын тамганы нэлээд бүрэн төгс хураамж цуглуулга бүрэлдэн бий болсон байна гэж болно. Рашаан хадны тамганы дурсгалангийн угсаа, удам, түүх-соёлыг судлахад үнэлж баршгүй чухалчлагдах гүн учир зүй нь үүнд оршино» гэж «Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь» нэгэн сэдэвт бүтээлдээ дүгнэжээ. Мөн тэрээр «... хадан самбарын байгаа нутаг нь монголчуудын унаган нутгийн хүйс нь байсан Гурван голын савд багтах бөгөөд эртнээс тахилгатай Биндэръяа хан уулын (овооны) дэргэд оршихын дээр Хураху гол хэмээх сонин нэртэй голын хөндийн умард захад байна. Хураху хэмээх үг бол цуглах, чуулах гэсэн утгатай юм» хэмээжээ.

Байгаль дэлхийтэй харилцан шүтэлцээтэй амьдарч тэнгэр, газар, усыг тахин бөө мөргөлийн шашинтай эртний овог аймгийн оршин тогтнож байх үед хад чулуугаар дамжуулан тэнгэр эрхэст өргөл тахил өргөх ёс нийтлэг байсныг судлаачид тайлбарласан



байдаг. Тиймээс өсөн үржсэн олон овог аймаг өөр өөрсдийн үндсэн сүлд, тамга тэмдгэн дээр үүсгэн бий болгосон овгийн үүсмэл тамга тэмдгийг нэмэн дээрх хавтант хад чулуун дээр сийлж, түүгээр дамжуулан тэнгэрт овгийн үржил өсөлтийг илтгэн тахилга хийдэг байсныг үгүйсгэхгүй.

Рашаан хадны энэхүү тамгат хавтан болоод ойр орчмын хад чулуунд мөн дээрх дүрс элбэг байхаас гадна мөн бөөгийн унаа хэмээн нэрлэдэг бугын дүрслэл байдаг нь сонирхолтой. Хэдийгээр хадны зургийн дүрслэл харьцангуй энд төдийлөн элбэг биш ч бугын дүрслэл маш тод байдаг билээ.

Рашаан хаданд буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл хэрхэн судлагдсан талаарх судалгааны товчлолын өмнө энэ дурсгалт газрын нэр эртний түүх бичгийн сурвалжид хэрхэн өгүүлэгдсэн байж болох тухай мэдээллийг хүргэе.

Академич Х.Пэрлээ «...Хурагу голын нэрийг эртний монголчуудын хаан Котола-г ширээнд өргөмжилсөн Корго-наг Жубур гэдэг газар болов уу гэж нутгийн зарим хүмүүс үздэг юм. ...Монголын түүхийг судлах гол сурвалж бичиг «Сударын чуулган»-д Хурагу (Уйгаржин бичгээр Курку гэж бичдэг) хэмээх үгтэй адилтгаж болох газрын нэр гарч байна. Тэнд бичсэн нь: Албин онгодын орон Гурку-Тасын газраа монголын Котола хан нутаглан сууж байсан гэжээ. (Оросоор I боть, 2-р дэвтэр, 29-р тал) Энэхүү Гурку нь Курку болов уу хэмээхийн хамт, Тас (Таш) нь чулуу гэсэн хуучин үг гэж таамаглаж байна. Бидний олсон хадан самбарын байгаа газар нь анхан буй цагт нь «Гурку тас» («Хуралдах чулуу») байсан тэр газар мөн болов уу. Түүнээс Хурагу гол нэр үүссэн гэж үзэж байна. Энэ газар бол, уул ус тэгширсэн уудам сайхан хөндийтэй, олон овог аймгийнхан хуралдан цуглаж болох зохилдуун нутаг билээ. ...Энэхүү Рашаан хадыг «догшин» гэж нутгийн сүсэгтэн гар хүрдэггүй байсан юм. Тэр нь XII зууны үеийн «албин онгод»-той газар гэж байсан үзлийн улбаа байх. Иймд урьдын цагийн Котола (хан) нутаглаж байсан Корко-наг Жубур, одоогийн Курку (Хурагу) гол цөм нэгэн газрын нэр гэж хүлээн зөвшөөрч болох байх» хэмээн үзжээ.



1973, 1974 онд Гурван голын шинжилгээний анги, 1979, 1980-1981 онд МЗТСХЭ-ийн Чулуун зэвсгийн дурсгал судлах анги, 1991 онд Монгол-Японы хамтарсан «Гурван гол» төслийн хайгуулын анги, 1997-2008 онд Монгол-Солонгосын хамтарсан Мон-Сол төслийн судалгааны анги, 2005 онд Япон-Монголын «Бичээс» төслийн хүрээнд, 2006 онд МУИС-ын МХХСС-ийн багш, манжич М.Баярсайханы удирдсан Эх бичиг судлалын анги болон ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид, 2008-2009 онд Соёлын өвийн төв, Япон улсын Нарагийн Соёлын өв судлалын газар, Дошиша их сургуулийн хамтарсан "Их Хэнтий" төслийн баг тус газарт судалгаа хийж байжээ.

Академич Д.Цэвээндорж «Монголын эртний урлагийн түүх» номондоо Рашаан хадны зураг, тамга тэмдгийн дүрслэлийн он цаг, төрөл зүйлийн тухай, профессор Г.Гонгоржав «Монголчуудын чулуун өв соёл» номондоо Монголчуудын голомт нутаг-«Задын газар» буюу Рашаан хад орчмын эртний шүтлэг, «Задын чулуу»-ны тухай, С.Бадрал «Монголын эртний чулуун баримал» номондоо Рашаан хадны дэргэдэх үхэр чулуун дээр хэдэн зуун тамга тэмдэг дүрсийг зурааслан цоолборлож дүрсэлсэн нь чулуун уран баримлыг бүтээх арга ажилагаа хадгалагдсан болох тухай, доктор Ж.Саруулбуян, А.Даваасамбуу нар «Монгол адууны тамганы ойллого» номондоо Рашаан хадан дахь морины дүрслэл нь монгол нутагт зурагдсан анхны морь дүрслэл болох тухай, Японы эрдэмтэн Т.Мацүкава, монголын судлаач Ц.Баттулга нар тэндэх монгол болон араб бичээс, доктор А.Очир, А.Жамсран нар хятад, монгол бичээсийг уншин тайлж судалгааны бүтээлүүд нийтлүүлжээ. Мөн А.П.Окдадников, Ш.Като зэрэг гадаадын эрдэмтэн судлаачид энэхүү дурсгалыг судалж, шинжлэх ухааны эргэлтэд оруулахад их хувь нэмэр оруулжээ.


1996 онд Монголын Соёлын сангаас зохион байгуулсан «Сувдан сондор», мөн Монгол Улсын Ерөнхийлөгч зохион байгуулан, оролцдог «Буурал түүхийн жимээр» аяллынхан Рашаан хадны дурсгалд очиж эрдэм шинжилгээ, судалгааны сонирхолтой яриа өрнүүлж, дурсгалыг цаашид хэрхэн бүрэн гүйцэд судлах, эндэх дурсгалыг хэрхэн хамгаалах талаар санал солилцож байжээ.



1996-1999 онд «Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал» сэдэвчилсэн лавлах толь бичиг зохиох, хэрэглэгдэхүүн цуглуулах хээрийн судалгааны үеэр зүүн бүс нутаг, ялангуяа Рашаан хад орчмын дурсгалыг аялал жуулчлалын чиглэлд хамруулж болох тойм судалгааг хийж байв.

Бид тус төслийн 2008-2009 оны судалгааны үр дүнд тогтоосон 12 дурсгалын дарааллыг баримтлан бүртгэсэн болно.

Үүнээс хойш 2006-2008 онд Монгол-Японы хамтарсан «Зүүн Монголын чулуун зэвсгийн судалгаа» төсөл, 2011-2014 онд Монгол-Солонгосын хамтарсан «IA-SNU» чулуун зэвсгийн судалгааны төсөл, 2015 онд Соёл, урлагийн их сургууль, ОХУ-ын Барнаулын Техникийн Их сургуультай хамтран «Орчин үеийн Сибирь болон Монголын дүрслэх урлагийн гарал үүслийн харьцуулсан судалгаа» төслийн баг зэрэг хэд хэдэн шинжилгээний анги ажилласан байна.



Рашаан хадны дэвсгэр зураглал



2.1. Хирст хад

Рашаан хадны зүүн хойд булангаас зүүн хойш 45 орчим м-т өрөгрөгийн дагуу 7.6 м сунаж тогтсон гурвалжиндуу хэлбэртэй хад юм. РН 01 хэмээн тэмдэглэгдсэн энэхүү хадны зүүн талын 2.6x2.0 м нар тоссон тэгш гадаргуу дээр нь 3 том амьтны сийлмэл зураг байдаг. Амьтдын зургийг бүх биеийнх нь гадаргуугаар хөвөөлөн цохиж гаргажээ. Амьтдын толгойг бүгдийг нь зүүн тийш харуулан толгойг нь бага зэрэг доош уншуулан сийлсэн байна. Судлаачид эдгээр зургийг савгат хирс, арслан зааны зураг хэмээн тодорхойлдог бөгөөд хуучин чулуун зэвсгийн дээд үе буюу 40000-14000 жилийн тэртээ бүтээгдсэн гэж үздэг.



Хирст хад

2.2. Кидан бичигт хад

Рашаан хаднаас зүүн тийш 46 орчим м, Хирст хаднаас зүүн урд зүгт 19 м зайд оршино. РН 02 хэмээн тэмдэглэгдсэн энэ хад нь эрт цагт голоороо өрөгрөгийн дагуу хагарч хоёр тийш болж тогтсон 2 хэсэг хаднаас бүрдэх бөгөөд дундаа шулуун давчуу зайтай. 2 хадны хойд талын урагшаа харсан хадны доод хэсгийн тэгш гадаргуу дээр 2 хэсэг газар Кидан бичээс бичжээ. Бичээсийг хар бэхээр бичсэн байх бөгөөд эдүгээ тайлж уншсан судлаач эрдэмтэн үгүй болно. Бид эдгээр бичээсийг



Рашаан хадны 5, 6-р кидан бичээс гэж бүртгэсэн.

5 дугаар кидан бичээс: Хөмгийн хоёр бичээсний баруун талынх нь юм. Бичээс маш их бүдгэрсэн, эдүгээ 3 мөр бичиг мэдэгдэнэ. Бичээсний өндөр 0,60 см, өргөн нь 0,30 см орчим юм. Дүрс үсгийн тоо ширхэг тодорхойгүй.

6 дугаар кидан бичээс: Хөмгийн хоёр бичээсний зүүн талынх нь юм. Мөн л ихэд бүдгэрсэн байв. Эдүгээ 2 мөр бичиг мэдэгдэж бөгөөд түүний өндөр нь 0,50 см, өргөн нь 0,20 см орчим ажээ. Бичээсний дүрс үсгийн тоо тодорхойгүй.



Кидан бичээс

2.3. Тамгат хавтан чулуу

RH 03 хэмээн тэмдэглэгдсэн Рашаан хадны зүүн талд 5 орчим м-т оршино. 6.55 орчим м урт, 2.95 орчим м өндөр 0.76 орчим дундаж зузаантай зүүн тийш харсан ханан хавтангийн гадаргуу дээр нийт 300 орчим тамга тэмдэг сийлж үлдээжээ.



Тамгат хавтан чулуу



Академич Х.Пэрлээ энэ хавтан чулууны тамга тэмдгийг тоолж зүүн талын тэгш гадаргуу дээрээ 180 гаруй, ар талдаа 40-өөд, сэрвээн дээрээ 50-иад нийтдээ 270-

аад тамга, тэмдэг дүрс байна гэж өгүүлжээ. Хавтан чулууны гадаргуу дээрх тамга тэмдгийн тоо чулууны гадаргууг дарсан олон жилийн хөрс шороог зайлуулахад нэмэгдэх боломжтой юм. Хавтан чулууны ерөнхий хэлбэр нь Монгол улсын газрыг зургийг санагдуулах ажээ.

Тамга тэмдгийн бүрдэлдэхүүнд үндсэн тамгууд болох онгин буюу наран, чойндон буюу гурвалжин тамга, саран тамга, туурай тамга, буйлан тамга, ширээ тамга, дэгрээ тамгууд голлохын зэрэгцээ тэдгээрээс салбарлуулан сийлсэн үүсмэл тамга тэмдгүүд хэдэн арваараа байна.

2012 оноос хойш бид Рашаан хад орчимд, тодруулбал РН 06, РН 07 орчмын дурсгалууд орших хадны оройд хөвөөлж сийлж зурсан адууны дүрслэл, РН 10 буюу морьт хаднаас 5 орчим м-т хаданд хар бэхээр зурсан соёмбо зэргийг тус тус олж бүртгэсэн бөгөөд зарим мэдээллийг урлаг судлаач, доктор С.Бадрал мэдээлсэн болно.

2.4. Гол бичигт хад

РН 04 буюу бидний өгүүлэн буй дурсгалын ойр орчмоор 10-аад төрлийн 30 гаруй бичиг үсгийн дурсгал байдгийг өмнө нь энэ дурсгалын орчимд судалгаа шинжилгээний ажил хийсэн эрдэмтэн судлаачид, хэл шинжлэлтэн нар өөрсдийн судалгааны ажилдаа түшиглэн тэмдэглэсэн байдаг. Мөн тэд эдгээр бичээсийг уншиж утга агуулгыг нь гаргаж ирэх талаар цөөнгүй ажил хийжээ. Гэвч өнөөдөр Рашаан хадны орчмын бичиг үсгийн дурсгалыг нарийвчлан тоолж байршлыг тогтоох, утга агуулгыг нь хэл зүйн үндэстэй гаргаж ирэх судалгааны дутуу дулимаг хэвээр байгаа билээ.



Рашаан хад, түүний орчмын бичиг үсгийн дурсгалыг тоолж баримтжуулах байршлыг тогтоох, зарим бичээсний тайлж унших, утга агуулгыг нь гаргаж ирэх ажлыг хийхэд уг дурсгалууд байршиж байгаа хад чулууны бүтцэд гарсан өөрчлөлтөөс шалтгаалсан өгөршилт багагүй хүндрэл учруулж байв.



Гол бичигт хад

- *Кидан бичээс, ■ Монгол бичээс, ■ Түрэг бичээс, ■ Түвд бичээс,*
- Араб бичээс, ■ Дөрвөлжин бичээс, ■ Хятад бичээс*

Биндэр уулын орчмын геологийн тогтцын бүрэлдэхүүнд том ширхэгт боржин, цахиур, хас хаш, хүрмэн чулуулгууд зонхилдог. Эдгээрээс хадны бүтцийн ихэнх хэсгийг бүрдүүлэгч нь том ширхэгт боржин чулуулаг байна. Боржин чулуу нь байгаль дээр ихэвчлэн цайвар, цагаан саарал өнгөтэй тохиолдох бөгөөд заримдаа улаавтар туяатай цайвар, ягаандуу туяатай цайвар, бараан саарал өнгөтэйгөөр тохиолдох нь бий. Чулуулгийн мөхлөгийн ширхэгээс шалтгаалж жижиг, дунд зэрэг, том ширхэгт боржин гэж ялгадаг. Том ширхэгт боржин чулуунд суларч бутрах үзэгдэл дунд зэргийн ширхэгт боржин болон жижиг ширхэгт боржин чулуудаа бодвол харьцангуй хурдацтай явагддаг ажээ.

Рашаан хадны орчмын боржин чулуун хад нь орчны температурын хэлбэлзэл, салхи, ус болон химийн идэвхтэй бодисууд, ургамал, амьтнаас ялгарах органик бодисуудын нөлөөгөөр ан цав гарах, хагарч гэмтэх, хуурч унах, үйрч бутрах, зэргээр бичиг үсгийн болон зураг, тамга тэмдгийн дурсгалыг



үлдээсэн үеийн төрх байдлаа алдаж гэмтжээ. Мөн хадны бичээс дээгүүр урсах хүчил шүлт ихтэй борооны усны нөлөөгөөр цагаан давхарга бий болж эрт үед зос болон хар бэхээр бичиж үлдээсэн бичээснүүдийн олонх нь бүдгэрч мэдэгдэхгүй болсон байв.

Рашаан хадны гадаргуу дээрх нарийвчилсан бүртгэл хийсний үр дүнд тус дурсгалт хадны гадаргуу дээр олон тооны бичиг үсэг, зураг, тамга тэмдгийн зүйлийг нэмж олсон бөгөөд энэ удаад цаг хугацааны давчим байдлаас болж зөвхөн бичээсний дурсгалыг бүртгэж авсан болно.

Рашаан хадан дахь олон төрлийн бичээсийг тус бүрээр нь ангилан өмнө нь судлагдсан болон 2009 оны судалгаагаар нэмж бүртгэн бүх бичээст дугаар өгөн төрөлжүүлэн гэрэл зурагт тэмдэглэгээг хийх оролдлогыг хийв. Энэхүү судалгааг өмнөх судлаачдын судалгааны хэрэглэгдэхүүн дээр хийхийн хамт бичээсний төрөл зүйл бүрийг өнгөөр ялган, тухайн төрөл зүйлийн бичээс Рашаан хадны орчим дахь бусад хадан дээр хэрхэн тэмдэглэгдсэн байгааг гэрэл зурган дээр байршуулахыг оролдохын хамт зарим нэгэн хэмжилтийг нүдэнд харагдахуйц байдлаар нь тэмдэглэхийг оролдов.

Рүни бичээс:

Рашаан хадны зүүн талын гадаргуу дээр нэг мөр сийлбэрлэж бичсэн түрэг бичгийн 2 дурсгал байдаг. Үүний 1-р бичгийг 1960-аад оны үед академич Х.Пэрлээ илрүүлэн олж судалгааны эргэлтэд оруулсан бол 2-р бичээсийг 1980-аад оны үед МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги илрүүлэн олжээ. Эхний бичээс нь хадны гадаргуугийн зүүн дээд хэсэгт «Да Мин...» гэсэн хятад бичгийн доор оршино. Нийт 8 үсэг зурлагатай бичгийн урт 20 орчим см урт, үсгийн өндөр дунджаар 4.3 орчим см өндөр юм. Энэхүү бичгийн утгыг түрэг судлаач С.Харжубай «атам апам ачиггун» хэмээн уншиж «эцэг өвгөдийн шан хишиг» хэмээн орчуулжээ. Энэ бичгийн ард урт шулуун иштэй шанаган хэлбэрийн сийлмэл тамга бий.

2009 оны судалгаагаар баг энэхүү 1 дүгээр бичээсний өндөр нь 4.5 см, нийт үсэг зурлагын урт 21.0 см гэж бүртгэлээ.

Хоёр дахь бичиг нь эхний бичгийн баруун доор 1.2 орчим м-ийн зайд байрлана. Бичээс өнөөгийн байдлаар нэлээд бүдгэрсэн



байдалтай байх бөгөөд зарим үсгийн зурлага нь бараг харагдахаа байжээ. Бичээсний урт 60 орчим см, үсгийн өндөр 16-21 орчим см байна. Бичээсний ард янгир сийлжээ. Энэ бичээсийг С.Харжубай «сат атыч ерти» гэж уншаад «зоригтой ач билээ» хэмээн [Харжубай 1978: 84] орчуулжээ. 2009 оны судалгаагаар 2 дугаар бичээсний өндөр 20 орчим см, нийт бичлэгийн урт 60.0 орчим см байна гэж бүртгэлээ. Түрэг бичгийн дурсгалын байршлыг зурагт шар өнгөөр тэмдэглэв.



Рүни бичээс

Араб бичээс:

Рашаан хадны зүүн талын гадаргуу дээр 5 мөр араб бичээс дурсгал бий. Байрлалын хувьд энэ бичиг нь хадны зүүн дээд хэсэгт хятад, түрэг бичгийн ойролцоо орших ажээ. Бичээсийн өндөр 0,27-0,28 орчим см, өргөн нь 0,28-0,30 орчим см, мөр хоорондын зай, 2-3 орчим см байлаа. Бичгийг хар өнгийн бэхээр ялимгүй таталгаж бичсэн байна. Өнөөдөр уг бичээсний 4-5-р мөр ихэд бүдгэрч танигдахын аргагүй болжээ. Энэ бичээсийг судлаач



Араб бичээс

Ц.Баттулга нар «эхний мөрийг буцах замаар илгээв. Өвчин зовлон хуурмаг... хоёрдугаар мөрийг бид асууцгаав. Тэвчээртэй... гуравдугаар мөрийг таньж мэдэхгүй газар...» хэмээн тайлж уншин орчуулсан [Баттулга нар 2006:87] байна.



Кидан бичээс:

Рашаан хадны зүүн талын олон бичээст гадаргуу дээр 4, болон түүнээс зүүн тийш 46 орчим м-т байх эрт цагт голоороо хагарч хоёр тийш болсон хадны хойд талын урагшаа харсан хөмөгт 2, нийтдээ 6 хэсэг газар кидан бичээс бий. Эдгээр бичээсийг бүгдийг нь хар өнгийн бэхээр бичсэн байх бөгөөд цаг хугацааны эрхээр бүдгэрч мэдэгдэхгүй болсон нь үлэмж их ажээ. Өнөөдрийн байдлаар уг бичээснүүдийг тайлж уншсан судлаач байхгүй байна.

Кидан бичгийн дурсгалын байршлыг зурагт цэнхэр өнгөөр тэмдэглэж хэмжээг нь авч бүртгэж баримтжуулав.

1 дүгээр кидан бичээс: Энэ бичээс нь гол бичигт хадны зүүн талын урд хэсэгт байрлана. Бүдгэрч харагдахдаа муу болсон. Бичээс нь нийт 27-28 мөр 0,78 м өргөн бичигтэй, мөрийн дундаж өндөр нь 0,16 м байв.



1 дүгээр кидан бичээс

2 дугаар кидан бичээс: Энэ бичээс нь 1 дүгээр бичээсний төгсгөлөөс доош 50.0 орчим см-ын зайд байрлана. 6-7 мөртэй, өндөр нь 30.0 см, өргөн нь 20.0 см орчим хэмжээтэй. Бичиг нь маш бүдгэрч, харагдахгүй шахам болсон.



2 дугаар кидан бичээс

3 дугаар кидан бичээс: Энэ бичээс нь 2 дугаар бичээсний хойд талд 0,50 см орчимд байрлах ба 3-4 мөр том хэмжээгээр бичсэн. Өндөр нь 83.0 орчим см, өргөн нь 23.0 орчим см хэмжээтэй.



3 дугаар кидан бичээс

4 дүгээр кидан бичээс: Энэ бичээс нь гол бичигт хадны зүүн талын зүүн дээд хэсэгт орших «Суут Чингис хааны» гэсэн



Монгол бичгийн орчимд байрлана. 12 мөртэй, өндөр 29.0 см, өргөн нь 34.0 см орчим юм.



4 дүгээр кидан бичээс

Дөрвөлжин бичээс:

Рашаан хадны олон бичээст гадаргуу дээр гуравдугаар кидан бичгийн зүүн доод талд 1 мөр дөрвөлжин бичиг бий.



Дөрвөлжин бичээс



Энэ бичгийн өндөр 8-10 орчим см, өргөн нь 2-2.5 орчим см юм. Бичээст хэдэн үсэг байгаа нь сайн мэдэгдэхгүй байна. Зарим судлаачид энэ дөрвөлжин бичгийг өмнөх кидан бичгийг бичсэн хүний нэр /гарын үсэг/ байж магадгүй гэсэн таамаглалыг дэвшүүлсэн байдаг. Дөрвөлжин бичгийн дурсгалын байршлыг зурагт саарал өнгөөр тэмдэглэв.

Хятад бичээс:

Рашаан хадны олон бичээст гол хадны зүүн талын гадаргуугийн зүүн дээд хэсэгт 1-р түрэг бичээсний дээд талд 1 хятад бичээс бий. Бичээс 4-5 мөр бөгөөд өндөр нь 22 см, өргөн нь 17 орчим см, мөр хоорондын зай 1 см байна. Академич Х.Пэрлээ уг бичээсний эхний хэдэн үгийг «Да Мин хуанди» гэж уншаад «XV дугаар зууны үед Монголыг цэрэглэн довтолж Хэрлэн гол хүртэл ирж Монголд ялагдаж байсан Чен-зу (Юн лу) хааны үлдээсэн бичиг байж магадгүй» хэмээн таамагласан [Пэрлээ 2001:124] байдаг. Хятад бичээсний байршлыг зурагт ягаан өнгөөр тэмдэглэв.



Хятад бичээс

Монгол бичээс:

Рашаан хадны зүүн, зүүн урагш харсан гадаргуу дээр нийт 23 урагш харсан гадаргуу дээр 6, хөрөгт хадан дээр 1, зурагт хадан



дээр 1 нийт 31 монгол бичээс байна. Бичээсийг бүгдийг нь хар бэхээр бичсэн бөгөөд ихэнх нь мэдэгдэхгүй болтлоо бүдгэрсэн байлаа. Академич Х.Пэрлээ «эдгээр бичээсний хэлбэр төрх хэв маяг 14-17-р зууны үед хамаарах» болохыг нягталжээ.

Эдгээр бичээсийг дахин нягтлан унших ажил өнөөдрийн байдлаар хийгдээгүй байна. Мөн урд талын гадаргуу дээр байгаа бичгээс уншиж судалсан зүйл үгүй болно. Энэ удаад Профессор А.Очир болон Японы монголч эрдэмтэн Мацукава нар бичээснээс уншиж болох зарим нэгэн бичээсийг дахин нягталж унших ажил хийсэн ч төдийлөн үр дүнд хүрсэнгүй. Ерөнхийдөө хар бэхэн бичээснүүдийн ихэнх нь бүдгэрч арилсан тул бичээсийг уншсан үр дүнг урагш ахиулах боломж маш муу байх төлөвтэй аж.

Рашаан хадны арын Хөрөгт хадны гурвалжилсан мухар (модтой) хэсгийн урагшаа харсан тэгш гадаргуу дээр 7 мөр монгол бичиг, Зурагт хадны баруун урд үзүүрийн хадны хөмгийн баруун талын амсар дээр 4 мөр монгол бичээсний тухай хойно тусгайлан өгүүлэх болно.

1 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь гол хадны зүүн талын баруун хэсэгт байрлана. 2 мөр бичээс нь 10.0 орчим см өндөртэй 4 см орчим өргөнтэй юм. Өмнө нь уншигдаагүй. Төслийн багийнхан ч уншиж чадаагүй юм.



1 дүгээр монгол бичээс



2 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 1 дүгээр монгол бичээсийг зүүн талд хадны хэвгийн дагуулан бичсэн бичээс юм. Бүдгэрч хадны гадаргуу дээр борооны усны нөлөөгөөр тогтсон нимгэн саарал давхаргад дарагдсан. 13 мөр бичээсний мөрийн өндөр 15.0 орчим см, өргөн нь 35.0 орчим см хэмжээтэй байв. Өмнө нь уншигдаагүй. Төслийн багийнхан уншаагүй.



2 дугаар монгол бичээс

3 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 2 дугаар бичээсний зүүн дор 42.0 орчим см-ийн зайд байрлана.



3 дугаар монгол бичээс



4 мөр бичээсний 1 дүгээр мөр нь тод боловч үлдсэн мөрийн бичээснүүд маш бүдэг байна. Бичээсний өндөр нь 14.0 см, өргөн нь 12.0 см орчим хэмжээтэй байлаа. Бичээсийг уншаагүй.

4 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь гол хадны зүүн талын дунд хэрд байрлана. 16 мөр бичээс байх бөгөөд ихэд бүдгэрч, зарим нь арилжээ. Бичээсний өндөр нь 35.0 орчим см, өргөн нь 40.0 орчим см хэмжээтэй. Бичээсийг уншаагүй.



4 дүгээр монгол бичээс

5 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 4 дүгээр бичээсний чанх дор байрлана. 6-7 мөр бүхий бөгөөд өндөр нь 38.0 орчим см, өргөн нь 17.0 орчим см хэмжээтэй. Бичээсийг уншаагүй.



5 дугаар монгол бичээс



6 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 4 дүгээр бичээсний зүүн талд буюу ертөнцийн зүгээр хойд талд нь байрлана. 5 мөр бичээсний өндөр нь 25.0 орчим см, өргөн нь 14.0 орчим см хэмжээтэй.



6 дугаар монгол бичээс

Бичээсийг академич Х.Пэрлээ «Тай Сун хааны зарлигаар дагасан, наманчилсан сөгдөж мөргөж бэлгэд /ж/ би /ч/ бэй» хэмээн уншсан [Пэрлээ 2001: 123] байна. Тэрээр бичээсний дунд гарч буй «Тайсун» хэмээх цолтой хааныг монголын сурвалж бичгээс шүүрдэн ХҮ дугаар зууны эхэнд Тогоон тайшийн дэмжлэгтэйгээр хаан суусан Чингис хааны угсааны Тогтабуха мөн хэмээн тодорхойлжээ.

Энэхүү бичээсний 1 дүгээр мөрөнд «Тайсун» гэсэн үгийг «хааны зарлигаар» гэх 2 дугаар мөртэй нэг түвшинд эхлэн бичсэн байна. Энэ нь дундад эртний Монгол бичгийн дурсгалуудад нийтлэг тааралддаг мөр тэтгэх дэг ёсны улбаа юм.

7 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь хадны хойд хэсэгт шувууны сангас болсон хэсгийн хойд талд 7 мөрнөөс бүрдсэн бичээс юм. Энэхүү бичээс бусад монгол бичээсийг бодвол харьцангуй тод сайн хадгалагдан үлдсэн байна. Бичээсний академич Х.Пэрлээ «Хоурм тингир-ту-гийн Тогуган /Тогоон/ тайшийн ... дөрвөн мянган /цэрэг/ Дайнсан чинсан мөргөн итгэж



бэлгэдэж (үсэг) талбибай» хэмээн уншсан [Пэрлээ 2001:123] байна.

Бичээсний өндөр нь 17.0 орчим см, өргөн нь 13.0 орчим см хэмжээтэй байв. Энэ бичээст нэр дурдагдаж буй «Тоуган» тайш бол ХҮ дугаар зууны үед Ойрадыг тэргүүлж явсан бөгөөд мөн оны дундуур өөрийгөө Монголын хаанаар өргөмжилж явсан түүхт хүн юм. Харин Дайнсан Чинсан гэх хүний талаарх мэдээ түүхэн сурвалжид тааралддаггүй аж. Бичээсний дунд нэр дурдагдах «Тайнсан чинсан» гэх нэрийг Тоуган тайшийн нэртэй нэгэн хэмжээнд өргөж бичсэн нь тэр цагийн төрийн том зүтгэлтэн байсан бололтой хэмээн академич Х.Пэрлээ тодотгожээ.



7 дугаар монгол бичээс

8 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 6 дугаар бичээсний доод талд ойролцоогоор 30.0-аад см-ийн зайд байрлана. 5 мөр бичээстэй ба өндөр нь 5.0 орчим см, өргөн нь 9.0 орчим см хэмжээтэй юм. Мөр хоорондын зай нь дунджаар 2.0 орчим см. Энэхүү бичээсийг академич Х.Пэрлээ «Оур хилэн нас бичиг бичсэн багш...» хэмээн уншиж төгсгөлд байсан хүний нэрийг баларсан хэмээн [Пэрлээ 2001:124] тодорхойлжээ.



8 дугаар монгол бичээс

9 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь 7 дугаар бичээсний баруун дор, сийлмэл жижиг түрэг бичээсний дээр (давхардан) байрлана. Бичээсийн өндөр нь 8.0 орчим см, өргөн нь 3,5 орчим см, мөр хоорондын зай 1,8 орчим см хэмжээтэй. Бичээсийг уншаагүй.



9 дүгээр монгол бичээс

10 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 8 дугаар бичээсний чанх доод хэсэгт байрлана. Бичээс 11-12 мөрөөс бүрдэх бөгөөд өндөр нь 19.0 орчим см, өргөн нь 32.0 орчим см юм. Бичээс бүдгэвтэр,



уншихад бэрхшээлтэй. Бичээсийн ард 2 салаа иштэй шанаган тамганы сийлмэл дүрс бий.



10 дугаар монгол бичээс


11 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь хятад бичээсний дээд хэсэгт байрлана. Бичээс нь 1 мөр бөгөөд өндөр нь 16.0 орчим см, өргөн нь 1,5 орчим см хэмжээтэй. Энэ бичээсийг академич Х.Пэрлээ «Суту Чингис хаган» хэмээн уншсан [Пэрлээ 2001: 123] байна. Энэхүү бичиг нь Рашаан хадны зүүн талын гадаргуу дээрх бичээснүүдээс хамгийн дээр байрлаж буй бичээс болно.



11 дүгээр монгол бичээс



12 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 9 дүгээр бичээсийн ард, нэгэн төвд бичээстэй хамт байрлажээ. Энэхүү бичээс 13-14 мөрнөөс бүрдсэн ба бүдүүн үстэй бийр ашиглан бичсэн байна. Өндөр нь 23.0 орчим см, өргөн нь 26.0 орчим см, мөр хоорондын зай 1.0 орчим см хэмжээтэй. Бичээсний дунд маань, мэгзэм бололтой төвд үгс тааралдаж байгаагаас үзвэл энэ бичээс нь дээд талын төвд бичээсний орчуулга байж магадгүй юм.



12 дугаар монгол бичээс

13 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 11 дүгээр монгол бичээсийн чанх дор хадны налууд байрлана. Бичээс нь 13-14 мөрнөөс бүрдэх ба өндөр нь 40.0 орчим см, өргөн нь 28.0 орчим см, мөр хоорондын зай 1.0 орчим см хэмжээтэй байв. Бичээсийн дунд тааралдаж буй төвд үгсийг харвал энэ бичээс нь төвд номын орчуулга бололтой ажээ. Бичээс буй хэсэг ус, эрдэслэг бодис, шохойжилтоос үүссэн гэмтэл, бохирдол ихтэй юм.



13 дугаар монгол бичээс


14 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь 11, 12 дугаар бичээсний баруун дээд хэсэгт хадны хагарлын хажууд байрлана. Бичээс байрлах хэсэг нь шохойжилтоос үүссэн бохирдол ихтэй аж. Энд 3 мөр бичээстэй ба бичээсний өндөр нь 14.0 орчим см, өргөн нь 7.0 орчим см, мөр хоорондын зай нь 2.0 орчим см хэмжээтэй байв.



14 дүгээр монгол бичээс



15 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь хадны ан цавын дээд талд, «Суту Чингис хаган»-ны гэх монгол бичээсний чанх хойд талд 80.0 см зайд, 3 мөр бичээсээс бүрдэнэ. Бичээсийн өндөр нь 14.0 орчим см, өргөн нь 4.0 орчим см, мөр хоорондын зай 1.0 орчим см хэмжээтэй юм. Бичээсийг уншаагүй.



16 дугаар монгол бичээс

16 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 14 дүгээр бичээсийн дээд талд байрлана.




16 дугаар монгол бичээс



Бичээс нь 2-3 мөрнөөс бүрдэх бөгөөд 6.0 орчим см өндөр, 3.0 орчим см өргөн, мөр хоорондын зай нь 2.0 орчим см хэмжээтэй юм. Бичээсийн байрлаж буй хэсэг мөн л шохойлог нимгэн давхарга бүхий бохирдолтой юм. Бичээсийг уншаагүй.

17 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 15 дугаар бичээсийн баруун дор байрлана. Бичээс 5-6 мөр бичгээс бүрдэх бөгөөд өндөр нь 23.0 орчим см, өргөн нь 9.0 орчим см, мөр хоорондын зай 2.0 орчим см хэмжээтэй юм. Бичээсийг уншаагүй.



17 дугаар монгол бичээс

18 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 14 дүгээр бичээсийн зүүн хэсэгт байрлана. Бичээс нь 9 мөрнөөс бүрдэх бөгөөд өндөр нь 18.0 орчим см, өргөн нь 19.0 орчим см, мөр хоорондын зай 2.0 орчим см хэмжээтэй ажээ. Бичээс хадгалалт сайтай ч үсэг зурлага нь хэлбэр төрх муутай тул уншихад төвөгтэй ажээ. Бичээсийг уншаагүй.




18 дугаар монгол бичээс

19 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь 17 дугаар монгол бичээсийн зүүн доод хэсэгт байрлана. Бичээс 6-7 мөрнөөс бүрдэх ба өндөр нь 48.0 орчим см, өргөн нь 14.0 орчим см, мөр хоорондын зай 1.0 орчим см хэмжээтэй байв. Бичээсийг уншаагүй.



19 дүгээр монгол бичээс

20 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 19 дүгээр монгол бичээсний зүүн талд байрлана. Уг бичээс 7 мөрнөөс бүрдэх бөгөөд өндөр нь 48.0 орчим см, өргөн нь 14.0 орчим см, мөр хоорондын зай 2.0 орчим см хэмжээтэй байлаа. Бичээсийг уншаагүй.



20 дугаар монгол бичээс

21 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь 12 дугаар бичээсийн зүүн талд байрлана. Бичээс 5-6 мөрнөөс бүрдэх бөгөөд өндөр нь 20.0 орчим см, өргөн нь 16.0 орчим см юм. Хажуу болон тээд талдаа төвд бичээстэй. Бичээсийн байрлал, зарим үгийн уншлагаас үзвэл уг бичээс төвд хэлээр монгол үсгээр бичсэн бололтой ажээ.



21 дүгээр монгол бичээс

22 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 21 дүгээр монгол бичээсийн зүүн доод хэсэгт байрлана. Бичээс 6-7 мөрнөөс бүрдэх



бөгөөд өндөр нь 17.0 орчим см, өргөн нь 19.0 орчим см хэмжээтэй ажээ. Бичээс ихээхэн бүдгэрсэн тул уншихад төвөгтэй болжээ.



22 дугаар монгол бичээс

23 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 23 дугаар монгол бичээсийн зүүн доод хэсэгт байрлана. Бичээс нь 10.0 орчим см өндөр, 30.0 орчим см өргөн, мөр хоорондын зай 2.0 орчим см хэмжээтэй байлаа. Сүүлээсээ 2 дахь мөрөнд «болтугай» гэж бичсэн нь уншигдана.



23 дугаар монгол бичээс



24 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь Рашаан хадны урд талын гадаргуугийн баруун доод хэсэгт байрлана. Бичээс нь 7 мөрөөс бүрдэх бөгөөд өндөр нь 22.0 орчим см, өргөн нь 12.0 орчим см, мөр хоорондын зай 2.0 орчим см хэмжээтэй байлаа.

Энэ бичээсний дээд талд 4-5 мөр бүдэг бичээс бий. Бичээсийг уншаагүй.



24 дүгээр монгол бичээс

25 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 24 дүгээр монгол бичээсээс зүүн тийш 2 орчим ийн зайд барлана. Бичээс 8-11 мөрнөөс бүрдэнэ. Бүдүүвтэр үстэй бийрээр бичсэн боловч уншигдахаар тод үлдсэн мөр, үсэг бараг байхгүй юм. Мөрийн дундаж өндөр нь 10.0 орчим см, өргөн нь 24.0 орчим см хэмжээтэй юм. Бичээсийг уншаагүй.



25 дугаар монгол бичээс

26 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 25 дугаар монгол бичээсийн доод хэсэгт байрлана. Нийт 4 мөрнөөс бүрдэнэ. Нарийн үстэй бийрээр бичсэн бололтой харагдана. Бичээсийн дундаж өндөр нь 12.0 орчим см, өргөн нь 10.0 орчим см хэмжээтэй юм. Бичээсийг уншаагүй.



26 дугаар монгол бичээс



27 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 24 дүгээр монгол бичээсийн зүүн дээд хэсэгт байрлана. Ихэд бүдгэрсэн тул бичээс үү эсвэл шулуун босоо уу гэдгийг нарийн тогтоох боломжгүй аж.

7 босоо мөрийн толгой буюу дээд хэсгийг зааглан хөндлөн зураас зурсан байдаг. Бид үүнийг 24 дүгээр монгол бичээс гэж бүртгэв. Ойролцоогоор 17.0 орчим см өндөр, 13.0 орчим см өргөн, мөр хоорондын зай 1,5 орчим см хэмжээтэй юм. Мөрийн дунд үсэг гэхээр дүрс харагдахгүй байна. Бичээсийг уншаагүй.



27 дугаар монгол бичээс

28 дугаар монгол бичээс: Энэ бичээс нь 27 дугаар монгол бичээсний зүүн дээд хэсэгт байрлана. Бичээс 3 мөр жижиг хэмжээний бичээс юм. Бичээсийг уншаагүй.



28 дугаар монгол бичээс

29 дүгээр монгол бичээс: Энэ бичээс нь 24 дүгээр монгол бичээсний дээд хэсэгт байрлана. Нийт 5-6 мөр жижиг хэмжээний бичээс юм. Ихэд бүдгэрсэн тул унших боломжгүй байв.



29 дүгээр монгол бичээс



Төвд бичээс:

Рашаан хад, болон түүний орчмын хадны гадаргуу дээр нийт 20 хэсэг газарт төвд үсгийн дурсгал байна. Зарим бичээсүүдийг улаан зосон зураг болон хар бэхээр бичсэн монгол, хятад бичээсүүдийн дээр давхардуулан бичсэн харагдана.



Төвд бичээс



Рашаан хадны арын Хөрөгт хадны хүний зургийн дээд талд том хэмжээтэй үсэг бүхий сийлмэл төвд бичгийн дурсгал бий. Мөн Рашаан хадны баруун урд талын тамгатай хэвтээ хавтангийн хойд ханан хадны дээд хэсэгт багавтар үсгээр бичсэн сийлмэл бичээс

байна. Бидний Зурагт хад хэмээн нэрийдсэн бугын зурагтай хадны баруун үзүүрийн хөмгийн ойролцоо хэд 5 төвд бичээс байх бөгөөд эдгээрийг хар бэхээр бичих, сийлбэрлэх гэсэн хоёр аргаар бүтээжээ. Бид энэ бичээснүүдийг хойно өгүүлэх болно.

Рашаан хад, түүний орчимд байгаа төвд бичгийн дурсгалуудыг хар бэхээр бичсэн болон хурц үзүүртэй зүйлээр сийлбэрлэж гаргах гэсэн хоёр аргаар үйлдсэн нь он цагийн хувьд ялгаатай гэж үзэх үндэслэл болж чадахгүй нь мэдээжийн хэрэг юм. Гэхдээ энэ хоёр аргыг нарийн шинжилж үзэх нь бага гэлтгүй зүйлийг мэдэж болох сэжиг болох юм.



Төвд бичгийн дотор ямар нэг түүхийн холбогдолтой мэдээ баримт байхгүй бөгөөд бүгдээрээ ерөөл магтаалын шинжтэй үгс байна. Жишээлбэл «Ум ма ни бад ми хум» гэх ерөөлийн үгс төвд бичээсний дотор олон байна. Мөн «ум а хум» гэх ерөөлийн үгс ч цөөнгүй харагдана.

Төвд бичгээр бичсэн бичээсний байрлалыг зурагт шар өнгөөр тэмдэглэв. Бид цаг хугацааны нөөц боломжоос шалтгаалан төвд бичээснүүдийн хэмжээсийг нарийн авч чадаагүй тул жишээ болгон төвд бичээсний зургийг үзүүлье.

2.5. Хөрөгт хад

Рашаан хадны баруун талын үргэлжилсэн мухар урт хадны баруун тийш харсан гадаргуу дээр RH 05 хэмээн тэмдэглэгдсэн уг сийлмэл хүний хөрөг байрлана. Хөргийг биеийн тэгээр хөвөөлөн цохиж сийлсэн байх бөгөөд хувцас, өмсгөлийн дүрслэлийг дан болон хос зураасаар гаргаж өгсөн байна. Хөрөгт толгойдоо бөмбөгөр оройтой зузаан хүрээтэй дүгрэг малгай гэмээр зүйл дүрсэлсэн байна. Үүнийг бурхны тэргүүнд дүрсэлдэг боолттой үс



Хөрөгт хадны гар зураг

гэж болмоор юм. Толгойн хоёр хажууд том дэлбээ бүхий чих дүрсэлсэн байна. Хоёр талын чих дүрсэлсэн зураас нь хүний эрүүн доогуур нумран үргэлжилж холбогджээ. Нүүрэнд хоёр хөмсөг дүрсэлсний баруун талынх нь долгиотой юм. Хөмсөгний дор хоёр нүд, нүдний дотор талын уулзвараас доош маш бүдэг зураас татаж үзүүрийг нь бага зэрэг долгиотуулан хамар дүрсэлжээ. Хамрын доод хэсэгт болхи дүрсэлсэн ам байна. Энэхүү амыг дүрсэлсэн хонхорхой нь байгалийн элэгдлээр хэлбэр төрх муутай болсон бус урлаачийн алдаанаас үүдэн урт амтай мэт болжээ. Цээжинд зөв энгэртэй өргөн захтай өмсгөл гэмээр дүрс гаргасан ч энэ нь дээлний дүрслэлээс өөр байна.

Жишээ нь, дээлний захыг мөрөнд нэлээд хэлхгэр байдлаар дүрсэлсэн баруун энгэрийн зах байхгүй зэрэг нь тухайн хөрөгт дээл өмсгөн дүрсэлсэн гэх санааг нотлох боломжгүй болгож



байна. Хөрөгт дүрсэлсэн өмсгөлийг лам нарын орхимжтой төстэй байдлаар дүрсэлсэн бололтой юм.



Хөрөгт хадны зураг

Учир нь баруун мөрөн дээгүүр хэсэг газарт орхимжийг хойноос нь давуулан гарган дүрсэлсэн байна. Баруун гараа доош тэнийлгэн хэсэг завилан суусан хөлөн дээрээ тавьсан байдалтай байх бөгөөд гарын хурууд болон шуу бугуйн урт нь бодит байдлаас нэлээд зөрүүтэй урт байх ажээ. Зүүн гарын байрлал мэдэгдэхгүй боловч цээжиндээ барьсан савыг доороос нь түшсэн мэт сэтгэгдэл төрөм муухан дүрслэл үзэгдэнэ.



29 дүгээр монгол бичээс

Хөргийн доод хэсгийн дүрслэл бүдгэрсэн байна. Энэхүү хөргийг академич Х.Пэрлээ 12-р зуунд хамаатуулан «Хамаг Монголын хан Хотулагийн хөрөг байж магадгүй» гэж үзсэн [Пэрлээ 2001: 127] байдаг. Харин Зөвлөлтийн эрдэмтэн

Э.А.Новгородова болон өөр зарим нэг судлаачид энэхүү зургийг бурхны хөрөг байж магадгүй талаар өөрсийн бүтээлдээ дурдсан байдаг ажээ.

Энэ нутгийн ард иргэд уг зургийг бурхны хөрөг буюу бурхны зураг хэмээн хэлэлцдэг бөгөөд зурагтай холбоотой ямар нэг хууч яриа, үлгэр домог үл мэдэх ажээ. Сийлмэл зургийн өндөр нь 174 см, өргөн нь 106 см.

Хөрөгт хадны хөргийн дээр 1 мөр 6 үг бүхий ерөөлийн төвд бичээс бий. Энэхүү бичээсийг 18-19-р зууны үед сийлсэн бололтой юм. Бичээсний толгойн доод талд зүүн тийш харуулан бүтэн биеэр нь хонхойлон цохиж гаргасан адууны гэмээр 2 сийлмэл зураг байна. Эдгээр амьтдын толгойг ялимгүй доош унжуулан дүрсэлсэн нь Хирст хадны зурагт дүрсэлсэн амьтдын ерөнхий зохиомжтой ижилхэн ажээ. /хөргийн толгойн баруун тушаа/

2.6. Монгол бичигт хад

Рашаан хадны арын Хөрөгт хадны урд талын гурвалжилсан мухарт ганц шүтлэгт хус бий. Энэ хусны хойд талын урагшаа харсан тэгш гадаргуу дээр RH 06 хэмээн тэмдэглэгдсэн 7 мөр монгол бичиг бий. Энэхүү бичээст «Ум ма ни бад ми ху» гэсэн ерөөлийн үгийг төвд галигаар монгол бичгээр эхлэл төгсгөлийг үл хамааран залгуулан 8-10 удаа давтан бичсэн байна. Мөн бичгийн мөрийн тэгш хэмийг алдагдуулан хоорондоо хэт их ойртох, холдох зэргээр бичжээ. Бичээсний эхний мөрийн дунд хэрд «ум» гэх үгийн урд нэг үг бичсэн байх боловч гаргагдахгүй



юм. Уг үгийн хэмжээ бичлэгийн хэлбэр, үсгийн хэвийг харахад «ум» гэх үгийг ямар нэг байдлаар засварласан үг биш бөгөөд магадгүй ерөөлийн үгийн эхлэлийг тодотгож өгсөн үг байж болох юм. Үсгийн хэвийг харахад бичгийн дадал чадвараар хомс гэмээр хүний гараар бичигдсэн гэх сэтгэгдэл төрж байлаа. Зарим судлаачид энэхүү бичээсний эхний хоёр мөр бичгийн ойр байгааг нягтлан хоёр өөр цагт бичсэн гэдэг.



Монгол бичигт хадны зураг

Бид энэхүү бичээсийг 30 дугаар монгол бичиг хэмээн дугаарлаж бүртгэсэн болно. Бичээс нь 7-8 мөртэй, мөр хоорондоо 1.5 орчим см-ийн хэмжээтэй бол бичээсний өндөр нь 74.0 орчим см, өргөн нь 21.0 орчим см хэмжээтэй ажээ.

Ямар болов ч бичлэгийн хэлбэр, хэв, дадал чадварын хувьд уг бичээсийг 17-19-р зууны үед бичсэн бололтой юм. Ойрын үед буюу 2008-2009 оны судалгааны үед энэ бичээсний дээр «11 А» гэх тоо, үсгийг чулуугаар үрж бичсэн байлаа.

2.7. Тамгат хэвтээ хад

RH 07 хэмээн тэмдэглэгдсэн дурсгал нь Рашаан хадны баруун урд талын зүүн урагшаа түрж тогтсон хадны зүүн урд талд



оршино. Дээш харсан хадны тогтоц дээр олон тооны тамга тэмдэг, шулуун зураас сийлбэрлэсэн боловч ус чийгэнд ил орших тул байгалийн нөлөөнд ихээхэн хэмжээгээр автжээ. Энд байгаа тамга тэмдгүүдийн дотор онгин тамга зонхилж байгаа мэт харагдах боловч эдгээрийн ихэнх нь туурай тамга бололтой юм. Учир нь энд сийлсэн онгин тамгын нэг тал нь задгай юм.

Тамга тэмдгийн голоор зэрэгцээ шулуун зураас байх бөгөөд зарим судлаачид үүнийг зам гэдэг. Бидний ажсанаар бол энэ шулуун зураасыг эртний хүмүүс сийлбэрлэж үлдээгээгүй уг чулуулгийн өөрийнх нь судал байсан бөгөөд бороо цасны ус урсах явцдаа хонхойлсон болов уу гэж бодогдохоор ажээ. Энд байгаа зарим чулуудад иймэрхүү шулуун зураас гарсан тохиолдол нэг бус удаа тохиолдож байлаа.



Тамгат хэвтээ хадны зураг

2.8. Зураг, бичигт хад

РН 08 хэмээн тэмдэглэгдсэн Рашаан хадны баруун урд талд өрөгрөгийн дагуу зэрэгцэн тогтсон хэсэг хэсэг цул хадны дунд хэсэгт, Хөмсөг хадны зургаас зүүн тийш 15 орчим м-т 1970-аад онд малтлага хийсэн хуучин хонхрын арын хаднаа хүн, амьтны зураг, бичээс, тамга, тэмдгийн дурсгал бий. Хадны зүүн талын тэгш гадаргуу дээр хүний тойм зураг, түүний зүүн талд зүүн тийш аруулан цувран зогссон гөрөөс болон бугын зургийг сийлбэрлэсэн байна. Хүний биеийг хөвөөлөн цохиж гаргасан бол хөл гарыг нь дан зураасаар гаргажээ.



Зурагт бичигт хадны зураг

Түүний зүүн талд байгаа амьтны биеийг арай жижиг гаргасан байх бөгөөд урт чихтэй богино сүүлтэй юм. Энэ сийлмэл зураг нь гөрөөсний төрхийг бүрэн агуулжээ. Түүний зүүн талд байгаа амьтныг гөрөөснөөс арай том урт сүрлэг зохиомж оруулан сийлбэрлэсэн нь бугын дүрсийг эрхгүй санагдуулна. Энд нэг сонирхолтой зүйл бол гөрөөсний зургийг биеийн тэгээр нь хөвөөлөн цохиж гаргасан бол бугын зургийг бүх биеэр нь цоолборлон гаргасан байв. Эдгээр зургийн зүүнтээ чойндон тамга бололтой дүрс тод харагдах бөгөөд түүний орчимд хэд хэдэн зураас мэдэгдэнэ. Зарим дүрслэлийн зураас бүдгэрсэн тул чухам юу болохыг нь тогтоох аргагүй байлаа.





Дээд дурдсан зургийн дурсгалаас баруун тийш 5-6 орчим м-т тамга тэмдэг, бичгийн дурсгал байна. Энд онги, нүдтэй онги, баавгайн сарвуу мэт дүрс байхын зэрэгцээ төвд монголоор бичиж сийлсэн бичээс байна. Бид энд буй монгол бичээсийг Рашаан хад орчмын 31 дүгээр бичээс хэмээн дугаарлаж бүртгэсэн болно.

2008 оны судалгаагаар 8 дугаар цэг хэмээн тодорхойлогдсон Зураг бичигт хадны баруун талд буй хадны хөмгийн баруун ирмэг дээр нэгэн монгол бичээс бий. Бид

энэ бичээсийг Рашаан хад орчмын 31 дүгээр монгол бичээс хэмээн дугаарлаж бүртгэсэн болно. Энэхүү бичээсийг академич Х.Пэрлээ «То ... угалж Лоу жил-үн ка...гуул /та...гуул/, басы алуур /иалуур/ түг бол... гури... бичиг-иен бакир /басар/ буюу бэкир, бэсир? - уун ...» хэмээн уншсан [Пэрлээ 2001: 124] байдаг.

Энэ бичээс нь 4 мөрөөс бүрдэнэ. Нилээд бүдгэрсэн боловч үсгүүд нь танигдахаар ажээ. Бичээсийн өндөр нь 13.0 орчим см, өргөн нь 7.0 орчим см хэмжээтэй.

2.9. Хөмсөг хад

RH 09 хэмээн тэмдэглэгдсэн энэхүү зургийн дурсгал нь адууны зурагтай хаднаас зүүн тийш 10 гаруй м-т урагш хошуурсан бөмбөгөр хадны урд талын дунд хэсэгт байрлана.

Энд эрт цагт хагарч унасан чулууны ором болох том хонхорт /монголчууд иймэрхүү хадыг хөмсөг хэмээн нэрийддэг тул бид энд ийнхүү нэрлэлээ/ элдэв төрлийн амьтны дүрс сийлсэн байна. Харамсалтай нь хавар зуны цагт бороо, цасны ус зургийн дээгүүр урсдаг тул зургийн ихэнх хэсэг нь бүдгэрч танигдахгүй болсон байна. Танигдах хэдэн дүрсийг тоймловол: зургийн зүүн талд баруун тийшээ харсан адуу бололтой дүрс, түүний өөдөөс угтуулан цуварч яваа мэт хэдэн амьтны дүрс /зээр ?/ түүний



баруун дээд доод талд тамга тэмдэг мэт хэдэн дүрс сийлжээ. Амьтны биеийг дан зураасаар тойм байдалтай дүрсэлсэн байлаа.



Хөмсөг хадны зураг

2.10. Морьт хад

RH 10 хэмээн тэмдэглэгдсэн Рашаан хадны баруун урд талд өргөргийн дагуу байрлалтай цувраа урт хадны баруун захад байх урагш хошуурсан /усан онгоцны хошуу мэт/ нэгэн хадны баруун урд талын хавтгай дээр нэг амьтны зураг бий.



Морьт хадны зураг



Сийлбэр зургийн зохиомж хэлбэр төрхөөс нь харахад гөрөөс юм уу эсвэл зээрийн дүрстэй илүү ойр мэт санагдана. Зургийг сийлэхдээ биеийнх нь тэгээр хөвөөлөн цохиж хөл, сүүлийг нь дан

зураасаар төлөөлүүлжээ. Амьтныг зүүн тийш харуулан сийлсэн байх бөгөөд соотон чихтэй богино сүүлтэйгээр зохиомжилжээ. Урд хоёр хөлийг нь тус тусад нь гаргасан бол хойд хоёр хөлийг нь давхардуулан нэг зураасаар гаргажээ. Уг зургийн урд буюу байгалийн зүгээр зүүн урд талд нь мөн адууны зураг болов уу гэмээр хэд хэдэн сийлбэрлэсэн зураас харагдах боловч өдгөө чухам ямар дүрслэл болох нь танигдахаа байсан байна.

2.11. Янгирт хад

RH 11 хэмээн тэмдэглэгдсэн энэхүү зураг нь RH 8 цэг буюу гөрөөс бугын зурагтай хаднаас урагш 13 орчим м-т орших дөрвөлжиндүү хэлбэртэй том хадны урагш харсан тэгш гадаргуугийн зүүн хэсэгт оршино.



Янгирт хадны зураг



Энд баруун тийш давхиж байгаагаар дүрсэлсэн 1 янгир, түүний доод хэсэгт чагтан тамга мэт ташуу иш, мөртэй 3 шүд бүхий сэрээ тамга, янгирын баруун дээд хэсэгт дан онгин тамга зэрэг дүрслэл тод мэдэгдэх бол бусад дүрслэл нь

бүдгэрч мэдэгдэхгүй болжээ. Эдгээр тамга зургийн баруун талд хэд хэдэн зураг тэмдгийн үлдэгдэл зураас бүдэг мадаг мэдэгдэх боловч чухам ямар дүрслэл болох нь мэдэгдэхгүй байна. Хадны зургийн орчимд чулуунаас нимгэн хуудсан чулууд нэлээд холцорч унасан харагдана. Энэ холцролт нь зарим зургийн хэсгийг дайрсан байлаа.

2.12. Баавгайн мөрт хад

RH 12 хэмээн тэмдэглэгдсэн Рашаан хадны урд үзүүрээс урагш 108 орчим м, тамгатай хэвтээ хавтан чулуунаас урагш 94 м-т 1,97 орчим м өндөртэй гурвалжиндуу тогтоцтой ургаа хад бий.



Баавгай хадны зураг



Энэ хадны урагш харсан тэгш гадаргуугийн дээд хэсэгт 6-7 баавгайн сарвуу мэт дүрсийг сийлжээ. Дүрсийн доод хэсэгт нь том зуувандуу дугуй ухаж сийлээд дээгүүр нь нумарч эгнэсэн байдалтай багавтар дугуй хонхор цохиж уг дүрсийг гаргасан байна. Энэ төрлийн дүрс энэхүү дурсгалаас холгүй орших Үзүүр цохио хэмээх хадны зургийн орчимд том жижиг 10 гаруй бий. Судлаачид эдгээр дүрсийг эртний хүмүүсийн баавгай шүтлэгийн зан үйлтэй нягт холбоотой гэж тайлбарладаг.

2.13. Тамгатай жижиг хавтан чулуу



Тамгатай жижиг хавтан чулуу

Дэвсгэр зурагт тэмдэглэгдээгүй үлдсэн олон тамгатай жижгэвтэр хавтан чулууг бид хугацааны сүүлээр олж RH 13 гэж тэмдэглэн бүртгэж авсан юм. Энэ хад нь Рашаан хадны зүүн хойд үзүүрээс зүгт 25 м, Хирст хаднаас

баруун урд зүгт 24 м, машин замын дэргэд оршино. Энэ чулууны нар тоссон 220х92 м орчим хавтгай гадаргуу дээр нэлээд хэдэн тамга тэмдгийн дүрс байна. Тод харагдаж буй тамга тэмдгийн бүрэлдэхүүнд туурай тамга зонхилох ажээ. Чулуун дээр сийлж үлдээсэн тамга, тэмдгийн ихэнх нь нар салхины нөлөөгөөр



мөлийж мэдэгдэхгүй болсон тамга тэмдгийн нарийн тоог гаргах боломжгүй болсон байна.

2.14. Зурагт хад

RH 14 хэмээн тэмдэглэгдсэн Рашаан хадны баруун талын мухар хадан дээр давхарлан тогтсон хадны (дээрээ жижиг чулуун овоолготой) урагшаа харсан толигор хавтгай дээр хэдэн амьтны дүрс сийлсэн байна. Бид энэхүү хадны зургийг RH 14 хэмээн тэмдэглэж бүртгэж авсан юм. Энд дүрсэлсэн амьтдын олонхыг нь биеийн тэгээр нь хөвөөлөн сийлсэн байна. Голд нэлээд томоор дүрсэлсэн буга гэмээр амьтны их биеийн хэсгийн чулуу нэлээд холцорсон тул мэдэгдэхгүй болжээ. Хадны баруун дээд хэсэгт урт эвэртэй янгир, зүүн доод хэсэгт хэдэн тамга дүрсэлсэн байлаа. Энэ хадны зургийн баруун урд талд байх том чулууны зүүн урагш харсан хаганд идэгдсэн тэгш гадаргуу дээр нэлээд том хэмжээтэй хэдэн амьтны дүрс сийлсэн боловч бараг харагдахгүй байна. Учир нь зургийг дарж зузаан хаг ургажээ. Мөн энд баавгайн сарвуу мэт дүрс хэд хэд бий.



Зурагт хадны чулуу


Гуравдугаар бүлэг

БИНДЭР УУЛ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛААЛТ ХАМГААЛААЛТЫН ТУХАЙ

3.1 Биндэр уул орчимд хамгаалалтын бүс тогтоосон тухай

Бүртгэл судалгааны баг Биндэр уул орчмын дурсгалыг хялбаршуулсан арга зүйгээр бүртгэн баримтжуулж, хамгаалалтын бүс хамааруулж болох нийт 10 цэгийг тогтоож газрын зурагт буулгасан болно. Эдгээр цэгийг авахдаа Биндэр уулын орчимд хамаарах дурсгалуудыг бүгдийг нь оруулах зарчим барьж ажилласан юм. Эдгээр 10 цэг нь:

Цэгийн дугаар	Координат	Тайлбар
1	N 48°22'603" E 110°17'967"	Рапаан хадны өврөөр явах машин замын дэргэдэх үхэр чулууны орчим
2	N 48°22'724" E 110°18'178"	Рапаан хадны зүүн урд өврийн хиргисүүрийн зүүн талд
3	N 48°25'138" E 110°17'936"	Хажуу нуурын буган чулуун хөшөөнөөс зүүнтээ 200-аад м-т
4	N 48°25'479" E 110°17'028"	Хажуу нуурын буган чулуун хөшөөнөөс баруун хойш 1,2 орчим км-т
5	N 48°25'175" E 110°11'441"	Өглөгчийн хэрмийн хойд хананаас хойш 200-аад м-т, Хэц уулын зүүн урд энгэрт
6	N 48°24'028" E 110°11'292"	Өглөгчийн хэрмийн баруун урд талд орших өвөлжөөний хойд талд
7	N 48°22'395" E 110°15'138"	Биндэр уулын баруун урд талын багавтар толгойн энгэрт
8	N 48°22'027" E 110°15'760"	Биндэр улын баруун урд хормой, худгийн зүүн талын дөрвөлжин булшны дэргэд
9	N 48°22'038" E 110°16'098"	Биндэр уулын урд хормой, замын урд талд байх хиргисүүрийн дэргэд
10	N 48°22'459" E 110°17'514"	Биндэр нуурын хойд эрэг, усны овооноос урагш 25 орчим м-т



Биндэр уул орчимд хамгаалалтын бүсийн зураг

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ны 135 дугаар тогтоолоор Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоосон байдаг. Энэхүү тогтоолд Рашаан хаднаас баруун хойш 7 орчим км-т байрлах Хажуу нуурын буган чулуун дурсгалуудыг оруулаагүй байв. Хажуу нуурын буган чулуун хөшөөд бол одоогоор Монгол нутгаас олноор байгаа буган чулуун хөшөөдийн хамгийн зүүн захад оршиж байгаагаараа онцлог юм. Бид тус хамгаалалтын бүст тус дурсгалыг оруулж тооцсоноор дээрх тогтоолд орсон газар нутгийг нэгтгээд зогсохгүй тус бүс нутгийн түүх, соёлын дурсгалыг бүрэн оруулсан болно. Түүнчлэн тус бүс нутгийн байгалийн нөөцийг давхар оруулсан юм.

Мөн 2009 оны бүртгэн баримтжуулалтын ажлын үндсэн ажлын нэг нь Рашаан хад орчмын 12 цэг дурсгалыг сонгон хамруулсан талбай бүхий газар зүйн хэмжилтийн зураглалыг хийсэн явдал байв. Энэ ажлыг Японы судлаач Аримура удирдан зохион байгуулж гүйцэтгэсэн бөгөөд дэвсгэр зургийг номын хоёрдугаар бүлэгт оруулсан билээ.

Дээрх хоёр зураглалыг үйлдсэнээр Биндэр уулын орчмын түүх, соёлын дурсгал, байгалийн нөөцийг хамруулсан хамгаалалтын бүс тогтоох бололцоотой болохыг тогтоосноос гадна анх удаа



Рашаан хадны орчмын дурсгалын байршлыг тэмдэглэсэн дэвсгэр зургийг үйлдсэн юм. Ялангуяа Рашаан хад орчмын дэвсгэр зургийг үйлдсэн ажлын үр дүнг энэ бүс нутаг судалгаа хийх ирээдүйн шинжилгээний ажилд хэрэглэгдэхүүн болгон ашиглах бүрэн бололцоотой юм.


3.2 Рашаан хаднаа хийсэн багажит дүн шинжилгээний судалгааны тойм

Соёлын өв тэр дундаа дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын нэгэн чухал хэсэг нь хүрээлэн байгаа орчин, түүний нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг олж тогтоох, хэмжилт судалгааг хийх явдал юм. Ийм төрлийн судалгааг орчин үеийн дэвшилтэд технологи ашиглан, шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж, үр дүнг гаргасанаар хадгалалт хамгаалалтыг дараагийн шатанд гаргах боломжтой юм.

Соёлын өвийн төв, Японы Нара хотын «Нарагийн хадгалалт хамгаалалт»-ын хүрээлэнгийн хамтран 2008 оны 9 сар, 2010 оны 8 дугаар сард тус тус богино хугацааны чулуун өв соёлын хадгалалт хамгаалалт чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг хээрийн нөхцөлд явуулсан юм. Дээрх судалгааны ажлын үр дүнг нэгтгэх, лабораторийн түвшинд чулуулгыг шинжилж судлах онол дадлага хийх сургалтыг 2010 оны 12 сард зохион байгуулж Нарагийн хадгалалт хамгаалалтын хүрээлэнд, монголын талаас 2 мэргэжилтнийг урьж ажиллуулсан билээ.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол нутагт байгаа хөдөлгөж тээвэрлэх боломжгүй чулуун дурсгалын хадгалалт хамгаалалтын арга зүйг нарийвчилсан суурь судалгаагаар бий болгох, эрсдэлийг тодорхойлж орчны нөлөөллийн судалгаа хийж материалын шинж чанар бүтцээр нь ангилж тодорхойлон гаргаж монголын нөхцөлд таарсан судалгааны арга зүйг нутагшуулахад чиглэсэн болно.


Бичээс бүхий хадыг гэрэл зургаар баримтжуулан, цаг уурын дулаан, чийгшилийн хэлбэлзлийг Улаанбаатар хот орчмын дулаан чийгшилтэй харьцуулан судлав. Дундаж температур 12 градус, чийгшил 70-80 хувьтай байлаа (зураг 1).



Зураг 1. Рашаан хадны хүрээлэн буй орчны чийгшил дулааны хэмжилт

Мөн чулуулгийн гадаргуун хувьд ch1 буюу чулуулгийн хойд гадаргуу, ch2 буюу баруун өмнөд хэсгийн чулуулгийн гадаргуу дээр тус тус хийсэн. Нарны тусгал бага тусдаг арын хэсэг нь 4 градус, нарны тусгал хамгийн ихээр нөлөөлөл авдаг баруун урд хэсэгтээ 27 градус байв (зураг 2).

зураг 2. Рашаан хадны чулуулгийн гадаргууд хийсэн дулааны хэлбэлзэл болон усны агууламжийн хэмжилт



Үүний дараа чулуулгийн гадаргуун усны агууламжийг хэт ягаан туяан багажит дүн шинжилгээг хийж бичээст дурсгалтай адил төрлийн чулуулгийн хэсэгт гадаргуун температурын хэмжилтийг хийв (зураг 3, 5).


Чулуулгийн хагарлын байдал. 2010 оны 8 дугаар сарын 21-нд чулуунд үүссэн хагарлын хэмжээг хэмжиж тогтоосон. Хагаралын хувьд кальцид эрдсийн нөлөөллөөр цууралт гэмтэл өгсөн ба нилээн урт хугацааны явцад явагдсан гэмтэл болох нь тодорхой байна.



Цагаан болон улаан өнгийн эрдсийн судалгаа. Бичээсний зарим хэсэгт цагаан болон улаан өнгийн хэсгүүд ажиглагдсан бөгөөд зөөврийн микроскопын тусламжтай улаан өнгө нь төмрийн эрдсийн нөлөөнд хувирсан нь тогтоогдсон. Гэвч улаан цагаан өнгийн хэсгүүдээс дээж авч лабораторийн шинжилгээ хийгээгүй учир нарийвчилсан орц найрлагыг тогтоогоогүй байна. 2010 оны судалгаагаар цагаарсан хэсгээс дээж аван рентген флуоресцент спектрийн шинжилгээ хийсний дүнд цагаарсан хэсэгт силикон илэрсэн. Мөн



Зураг 3. Чулууллагын гадаргууд хийсэн усны агууламжийн хэмжилт



зураг 4.

хөнгөн цагаан, кали, кальци, төмрийн эрдэс илэрсэн (зураг 4). Чулуулгийн борлосон хэсгийн рентген флуоресцент спектрийн шинжилгээний дүнд кальцийн найрлага илрэв.




Зураг 5. Хадны гадаргуу дээр хэмжилт хийсэн цэгүүд, шинжилгээний хэмжилт



Энэхүү судалгааны явцад дээрх чулуун дурсгалын хувьд байгалийн эрс тэрс уур амьсгалын нөлөөнд урт хугацааны элэгдэл хорогдол амсаж, газрын хөрсний эрдэс найрлагын нөлөөнд мөн орж муудсан нь тодорлогдож байна. Гол нөлөөлөл үзүүлсэн эрдсийн найрлагад силикон Si, төмөр Fe, мөнгөн ус Hg, хар тугалга Pb, алт Au зэрэг эрдсүүд илэрлээ.

3.3 Рашаан хаданд хийсэн 3 хэмжээст баримтжуулалт

Соёлын өвийн дурсгалын хадгалалт хамгаалалтын ажлын нэгэн чухал хэсэг нь түүний байршил, хэлбэр дүрсийг нарийвчлан хэмжиж, бүртгэн баримтжуулах явдал юм. Дэлхий дахинаа соёлын өвийг баримтжуулалтанд уламжлалт гар хэмжилт, гэрэл зураг, гар зураг зэргийг түгээмэл ашиглахаас гадна сүүлийн жилүүдэд 3D баримтжуулалтыг түгээмэл ашиглах боллоо. Учир нь сүүлийн үеийн техник, технологийн хөгжил хүний гараар хийгдэх хэдэн мянган (сая) хэмжилтийг хэдхэн секундэд хийх боломжийг олгодог байна. 3D хэмжилт хийх хэд хэдэн арга байх бөгөөд судалж буй дурсгалын овор хэмжээ, судалгааны цар хүрээ зэргээс шалтгаалж аль тохиромжтойг нь сонгон хэрэглэдэг.




Рашаан хадны 3D хэмжилтийн загвар



3D сканнер гэдэг нь бодит ертөнц дахь физик биетийг лазер, гэрэл эсвэл x-гау ашиглан олон мянган хэмжилт хийж 3D цэгэн мэдээллийг компьютерт хадгалах зориулалттай төхөөрөмжүүдийг хэлдэг.

Лазер сканнер нь секундэд хэдэн арван мянган (зарим нь хэдэн сая) хэмжилтийг өндөр нарийвчлалтайгаар хийж 3D мэдээлэл цуглуулах боломжтой байдаг. Ингэж цуглуулсан 3D мэдээллийг (Point cloud) компьютерт боловсруулж нарийвчилсан судалгаа болон олон нийтэд сурталчлах ажилд ашиглах боломжтой.

Соёлын өвийн төв 2008 оноос эхлэн Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг 3D-ээр бүртгэн баримтжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн билээ. Рашаан хадны дурсгалын тухайд 3D баримтжуулалтын ажлыг 2013 оны 8-р сард хийж гүйцэтгэсэн юм. Судалгааны багт СӨҮТ-ийн програмист Б.Алтансүх (Багийн ахлагч), техникч П.Чинбат, Япон улсын Нарагийн соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн судлаач Ямагучи Хироши, Нарагийн их сургуулийн судлаач Абей Рай нар ажиллав.




Рашаан хадны 3D хэмжилтийн загвар



Энэхүү 3D баримтжуулалтад Faro Focus 3D болон Konica Minolta Vivid 9i маркийн хоёр төрлийн лазер сканнер ашигласан болно. Faro Focus 3D бол 60 см-аас 120 метр хүртэлх зайд +/-2 мм хүртэл нарийвчлалтайгаар секундэд 976,000 цэг хэмжилт хүчин чадалтай лазер сканнер юм. Faro Focus 3D лазер сканнераар Рашаан хад орчмыг бүхэлд нь сканнер хийж авав. Харин Vivid 9i лазер сканнераар Рашаан хад орчмын зарим онцлох тамга тэмдэг, сийлмэл зургийн дүрслэлийг тусгайлан авсан болно.

Хоёр төрлийн 3D сканнер ашиглан хэмжиж авсан 3D цэгэн үүл мэдээллийг компьютерт оруулан 3D модель боловсруулах тусгай зориулалтын Geomagic XOS програм хангамж ашиглан нэгтгэн боловсруулж холбогдох мэдээллийг Соёлын өвийн төвийн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалсан болно.



Рашаан хадны 3D хэмжилтийн загвар

Ном зүй:

- Амартүвшин, 2003** - Ч. Амартүвшин. Эгийн гол дахь дөрвөлжин булшны судалгааны зарим асуудал // Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиумын илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар,
- Базаргүр нар..., 2015** - Д.Базаргүр, Б.Гүнчинсүрэн, Г.Эрэгзэн, П.Алдармөнх, И Сон Бук, И Жон Он. Рашаан хадны чулуун зэвсгийн суурингийн малталга судалгааны 2014 оны ажлын үр дүнгээс // Монголын археологи - 2014. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны хээрийн судалгааны үр дүн. Улаанбаатар,
- Баттулга нар..., 2006** - Ц.Баттулга, Ё.Алтан, Б. Азжая. Рашаан хадны араб бичээс // Mongolian Journal of Anthropology Archaeology and Ethnology. Official Journal of the National University of Mongolia. Volume 2. №2 (271) Улаанбаатар,
- Вяткина, 1951** - К.В. Вяткина Археологические памятники в Монгольской Народной Республике. СА, 1951, №1,
- Гурван гол, 1990-1993** - Монгол-Японы хамтарсан Гурван гол төслийн хээрийн шинжилгээний тайлан. 1990-1993 он, ТХГБСХ,
- Гүнчинсүрэн нар..., 2015** - Б.Гүнчинсүрэн, Г.Эргэзэн, П.Ардармөнх, И Сон Бук, И Жон Он. Рашаан хадны чулуун зэвсгийн суурингийн малталга судалгааны 2014 оны ажлын үр дүнгээс // Монголын археологи - 2014. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны хээрийн судалгааны үр дүн. Улаанбаатар, т.11-18.
- Даваацэрэн, 2009** - Даваацэрэн Д. «Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын ул хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсэн ажлын тайлан» Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан. Улаанбаатар,
- Даваацэрэн, Анхсанаа, Мижиддорж, 2010** - Б.Даваацэрэн, Г.Анхсанаа, Э.Мижиддорж, Дөрвөлжин булшинд холбогдох нэгэн зан үйлийн тухай // Улаанбаатарын их сургууль.



- Нийгмийн ухааны факультет. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. №5 (4). Улаанбаатар,
- Дашилхамаев, 2012** - Д.М.Дашилхамаев. Оленные и сторжевые камни Забайкалья // Гуманитарный вектор. 2012 №2 (30). Чита.
- Дорж,Новгородова, 1975** - Д.Дорж, Э.А.Новгородова. Петроглифы Монголии. Улаанбаатар,
- Доржсүрэн, 2003** - Ц. Доржсүрэн. Улсын төв музейд байгаа чулуун зэвсгийн зүйлс // Археологийн судалгаа. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. Улаанбаатар
- Доржсүрэн, 2003б** - Ц. Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсгийн судалгаа // Археологийн судалгаа. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. Улаанбаатар,
- И Сонбук, 2018** - И Сонбук. Рашаан хадны малтлага судалгааны зарим үр дүн // Studia Archaeologica, Tomus XXXVII. Fasc 2. Улаанбаатар, т. 17 -29. (Солонгос хэлнээс орчуулсан Г.Эрэгзэн)
- Монгол нутаг дахь түүх, соёлын..., 2006** - Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт. Улаанбаатар,
- Монгол нутаг дахь..., 1999** - Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах). Улаанбаатар,
- Монголын чулуун зэвсгийн судалгаа, 2016** - Монголын чулуун зэвсгийн судалгаа I. (Палеолитын үе: Соёлт давхаргатай суурингууд) Ред: Б.Цогтбаатар, Ц.Болорбат. Улаанбаатар, 380 тал
- Монголын чулуун зэвсгийн судалгаа, 2016** - Монголын чулуун зэвсгийн судалгаа I. (Палеолитын үе: Соёлт давхаргатай суурингууд) Ред: Б.Цогтбаатар, Ц.Болорбат. Улаанбаатар,
- Наваан нар..., 2008** - Д.Наваан М.Эрдэнэ, Д.Хатанбаатар, Д.Түмэн. «Дорнод Монгол» төслийн хүрээнд 2008 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. // Mongolian Journal of Anthropology Archaeology and Ethnology. Official Journal of the National University of Mongolia Volume 4. №1 (312) Улаанбаатар,



- Наваан, 1975** - Д.Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. Улаанбаатар,
- Новгородова, 1983** - Э.А. Новгородова. Аршан-Хад - древнейший памятник изобразительного искусства Восточной Монголии // История и культура Центральной Азии. Москва,
- Окладников., Васильевский, 1982** - А.П.Окладников, Р.С. Васильевский. Новые исследования Аршан-хад в Монголии. Из.СОАН, СССР, №6, Вып. 2 серия общественных наук,
- Өлзийбаяр, 2003** - С. Өлзийбаяр. Өглөгчийн хэрэм доторх нэгэн монгол булш. // МУИС-ийн Археологи, Антропологи, Угсаатан судлал сэтгүүл. Улаанбаатар,
- Өлзийбаяр, Хасархүү, 2018** - С.Өлзийбаяр, Б.Хасархүү. Дөрвөлжин булш ба буган хөшөөний хамаарлын асуудалд // Древние культуры Монголии, Байкальской Сибири и Северного Китая. Материалы IX Международной научной конференции (г. Улан-Удэ, 10-14 сентября 2018 г.) Том I.
- Пэрлээ, 1976** - Х. Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь Улаанбаатар,
- Пэрлээ, 1977** - Х.Пэрлээ. Хүн чулуун хөшөөний үүсэл хувьслын судлах асуудалд // Археологийн судлал. Том VII. Fasc .2. Улаанбаатар,
- Пэрлээ, 2001а** - Х.Пэрлээ. Дорнод Монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл //Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II боть. Улаанбаатар,
- Пэрлээ, 2001б** - Х.Пэрлээ. Монгол орны археологийн шинжилгээний тойм //Эрдэм шинжилгээний өгүүллүүд. I боть. Улаанбаатар,
- Пэрлээ, 2001в** - Х.Пэрлээ. Тодруулж судлууштай нэгэн түүхт хөрөг // Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II боть. Улаанбаатар,
- Пэрлээ, 2012** - Х.Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. Х.Пэрлээ. Бүтээлийн чуулган. Боть II, Улаанбаатар,
- Төрбат, 2000** - Ц. Төрбат. «Сэргэ» эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент.// Угсаатан судлал (Сибирь)



- болон Монголын ард түмгий угсаатний зүй). Том XII. Fasc 14. Улаанбаатар,
- Төрбат, 2003** - Ц. Төрбат. «Сэргэ» эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент. // Угсаатан судлал. Том XII. Fasc 14. Улаанбаатар
- Харжубай, 1978** - С. Харжубай. Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүд // Хэл зохиол. №16. Улаанбаатар,
- Цогтбаатар нар, 2010** - Б.Цогтбаатар Ц. Болорбат, Д. Одсүрэн. Улаан хадны зэвүүд // Studia Archaeologica, Tomus IX (XXIX). Fasc. 5. Улаанбаатар,
- Цогтбаатар нар..., 2010** - Б.Цогтбаатар, Ц.Болорбат, Г.Ахүндэв, Д.Одсүрэн. Рашаан хад, Өглөгчийн голын эх орчимд хийсэн чулуун зэвсгийн хайгуул, малтлага судалгааны зарим үр дүнгээс // Studia Archaeologica, Tom. (IX)XIX, Fasc. 2. Улаанбаатар,
- Цогтбаатар, 1998** - Б.Цогтбаатар. Бугахайрханы хуучин чулуун зэвсгийн дурсгал // Studia Archaeologica, Tom. XVIII, Fasc. 4. Улаанбаатар,
- Цогтбаатар, 1999** - Дорнод Монголын палеолитын үе (Онон, Хэрлэнгийн сав нутгийн дурсгалаар) Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 1999
- Цогтбаатар, 2003** - Б.Цогтбаатар Онон, Хэрлэнгийн сав нутгийн палеолитын судалгаа // Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиумын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар,
- Цыбиктаров, 1998** - А.Д.Цыбиктаров. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Удэ,
- Цыбиктаров, 2016** - А.Д. Цыбиктаров. Оленные камни и культура плиточных могил // Древние культуры Монголии, Байкальской Сибири и Северного Китая. - Красноярск,
- Цэвээндорж, 1988** - Цэвээндорж Д. Олон үеийн дурсгал Рашаан хад. ШУА,1988, №1. 64-66-р тал
- Цэвээндорж, 1999** - Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар,



- Цэвээндорж, 2003** - Д.Цэвээндорж. Олон үеийн дурсгалт Рашаан хад // Монголын археологийн судалгаа (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл) 1983-1992. II боть. Улаанбаатар,
- Цэвээндорж, 2003** - Д.Цэвээндорж. Түмэн жилийн түүхийн нэгэн сурвалж // Монголын археологийн судалгаа (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 1972-1983. Боть I. Улаанбаатар,
- Энхбат, Даваацэрэн, 2010** - Г.Энхбат, Б.Даваацэрэн. 2009 онд Монгол-Японы хамтарсан «Great Khentii» төслийн хүрээнд Сэрвэн хаалга, Биндэр уул, Рашаан хадны орчим хийсэн үл хөдлөх дурсгалын бүртгэлийн ажлын тайлан. Соёлын өвийн үндэсний төв. Улаанбаатар,
- Lumnr Jisl et Namsrai Ser-od-jave.** Riscntes decouvertes de cravures et peintures rupestres, d' habitats, nicroples et munuments turcs en la girpublique populaire de Mongolie // Намсрайн Сэр-Оджав. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар,



Рашаан хадны бэхээр зурсан соёмбо